

ХАСБАНК ХК-ИЙН 2025 ОНЫ ЖИЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ТАЙЛАН

СЗХ-ны 2021 оны 06 дугаар сарын 11-ний өдрийн 225 дугаар тогтоолоор баталсан "Үнэт цаасны бүртгэлийн журам"-ын 4 дүгээр хавсралт

Жилийн үйл ажиллагааны тайлагнал /Маягт 1/		
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйлд Үнэт цаас гаргагчийн нийтлэг үүргийг хуульчилсан бөгөөд үнэт цаас гаргагч нь жилийн үйл ажиллагааны тайлан дараах маягтын дагуу Санхүүгийн зохицуулах хороо, арилжаа эрхлэх байгууллагад мэдээлэл ирүүлж, өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлэл хүргэх үүрэгтэй.		
Тайлагнах хугацаа	2025 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдөр	
Үнэт цаас гаргагчийн мэдээлэл	Үнэт цаас гаргагчийн нэр: ХасБанк ХК УБГД: 9007001007 Үнэт цаасны симбол: ХАС Утасны дугаар: +976-75771888	
Бүртгэлтэй арилжаа эрхлэх байгууллагын нэр	Монголын Хөрөнгийн Бирж ХК	
Бизнесийн үйл ажиллагааны салбар	Банк, санхүү	
Жилийн эцсийн санхүүгийн тайланд аудитын дүгнэлт гаргасан СЗХ-нд бүртгэлтэй аудитын компанийн нэр, бүртгүүлсэн огноо	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК Бүртгүүлсэн огноо: 2013 оны 05 дугаар сарын 08	
Үнэт цаас гаргагчийн гаргасан нийт хувьцааны тоо ширхэг	1,052,700,000 ширхэг энгийн хувьцаа	
Жилийн тайланг бэлтгэсэн мэргэжилтэн, хянасан албан тушаалтны нэр	Бэлтгэсэн: Б.Буяннэмэх /Олон улсын санхүүжилтийн хэлтсийн ахлах шинжээч/ Хянасан: Г.Тамир /Санхүү хариуцсан захирал/ Хянасан: Н.Мөнхцэлмэг /Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга/	
1.	Тайлант жилийн санхүүгийн тайлан	
	Санхүүгийн байдлын үзүүлэлт	Хөндлөнгийн хараат бус аудитораар баталгаажсан 2025 оны санхүүгийн тайланг Хавсралт №1-д оруулав.
	Орлогын тайлан	
	Өмчийн өөрчлөлтийн тайлан	
	Мөнгөн гүйлгээний тайлан	
1.1.	Жилийн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлт	
	Хөндлөнгийн хараат бус аудитораар баталгаажсан 2025 оны санхүүгийн тайланг Хавсралт №1-д оруулав.	
1.2.	Аудитын тодорхойлох захидал /тодорхойлох захидлыг энэхүү зааварт дурдсан агуулгын хүрээнд боловсруулсан байх/	
	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК нь Аудитын Олон Улсын Стандарт ("АОУС")-ын дагуу хараат бусаар ХасБанкны 2025 оны жилийн эцсийн санхүүгийн тайланд хөндлөнгийн аудит хийж гүйцэтгэв. Тус аудитаар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх ХасБанкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл ("НББОУСЗ")-өөс баталж гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд ("СТОУС")-ын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлэгдсэн гэж дүгнэсэн юм. Уг дүгнэлтийг "Хараат бус аудиторын тайлан"-д /Хавсралт №1/ тусгасан болно.	

2.	Үнэт цаас гаргагч нь тайлант хугацаанд санхүүгийн нөхцөл байдал, үйл ажиллагааны үр дүнд нөлөөлсөн хүчин зүйлс, удирдлагаас өгсөн үнэлгээ, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар товч тайлбарласан тайлан, мэдээлэл			
2.1.	Үйл ажиллагааны үр дүн /санхүүгийн харьцааны үзүүлэлтүүд/	Ашигт ажиллагаа: ХасБанк 2025 онд 172.6 тэрбум төгрөгийн татварын дараах цэвэр ашигтай ажилласан ба өмнөх оноос 0.5 хувиар өссөн байна. Тайлант хугацаанд банкны ашигт ажиллагаанд зээлийн багцын өсөлт эергээр нөлөөлсөн бол своп хэлцлийн зардал, заавал байлгах нөөцийн нэмэгдэл, чанаргүй зээлийн өсөлт зэрэг нь сөргөөр нөлөөлжээ. 2025 оны жилийн эцсийн байдлаар Банкны өөрийн хөрөнгийн өгөөж буюу ROE 21.8 хувь, нэгж хувьцаанд ногдох ашиг буюу EPS 164.1 төгрөг байна. Нийт зээл: Тайлант хугацаанд нийт зээл болон санхүүгийн түрээсийн багц 4,183.3 тэрбум төгрөгт хүрч, оны эхнээс 13.1 хувиар өссөн байна. Үүнд: • Хэрэглээний болон бичил, ЖДБ зээлийн өсөлтийн нөлөөгөөр иргэдийн зээлийн багц 4.8 хувиар нэмэгдэж, 2,710.1 тэрбум төгрөгт хүрсэн, • Байгууллагын банкны зээлийн багц 26.6 хувиар өсөж 814.5 тэрбум төгрөг хүрсэн, • Улсын дугаартай болон дугааргүй автомашины санхүүгийн түрээс, орон сууцны зээлийн багцын өсөлтийн нөлөөгөөр Хаслизинг санхүүгийн түрээс, зээлийн багц 41.1 хувиар өсөж, 658.7 тэрбум төгрөг хүрсэн нь голчлон нөлөөлсөн байна. Харилцагчаас татсан эх үүсвэр: 2025 оны жилийн эцсийн байдлаар Банкны нийт харилцагчаас татан төвлөрүүлсэн харилцах болон хадгаламжийн үлдэгдэл 3,749.4 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оноос 9.5 хувь өссөн үзүүлэлттэй байна. Тайлант хугацаанд дотоод эх үүсвэрийг нэмэгдүүлэх зорилтын хүрээнд зах зээлийн эрэлт, харилцагчдын хэрэгцээнд нийцсэн олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгосон ба хуримтлалын соёлыг дэмжих зорилгоор банкны салбарт тэргүүлэх шагналын сантай хадгаламжийн урамшуулалт аяныг зохион байгуулж, амжилттай хэрэгжүүлсэн нь дотоод эх үүсвэрийн өсөлтөд эергээр нөлөөлжээ. Гадаад эх үүсвэр: ХасБанк 2025 оны тайлант жилд ADB, EBRD, Proparco, FinnFund, Incofin, DWM, Symbiotics зэрэг дэлхийн нэр хүндтэй санхүүгийн байгууллагуудаас нийт 272.5 сая ам.долларын гадаад эх үүсвэрийг татан төвлөрүүлсэн юм. Ингэснээр ХасБанкны гадаад зээлийн хэмжээ оны эцэст 548 сая ам.доллар хүрч өмнөх оны мөн үеэс 22.0 хувиар өссөн байна. Мөн 2025 оны 12 дугаар сард Нидерландын Хөгжлийн Агентлаг (FMO)-тай 150 сая ам.долларын синдикат зээлийн гэрээг байгуулсан ба тус гэрээний санхүүжилтийг 2026 оны 2 дугаар улиралд татан төвлөрүүлэх төлөвлөгөөтэй байна.		
2.2			Монголбанкнаас тогтоосон байвал зохих хэмжээ	2025-12-31-ний байдлаарх үзүүлэлт
		Нэгдүгээр зэрэглэлийн өөрийн хөрөнгө болон	>12.5%	20.1%

	<i>Хөрвөх чадвар болон санхүүгийн нөөц, боломжийн үзүүлэлт</i>	эрсдэлээр жигнэсэн активын зохистой харьцаа		
		Өөрийн хөрөнгө болон эрсдэлээр жигнэсэн активын харьцаа	>12%	20.1%
		Төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа	>25%	37.6%
		Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нэгж валютаар)	+/- 15% дотор	-1.2%
		Гадаад валютын нээлттэй позици болон өөрийн хөрөнгийн харьцаа (нийт валютаар)	+/- 30% дотор	-1.2%
		Нийт томоохон зээлдэгчдэд олгох активын төвлөрлийн харьцаа	<300%	54.8%
		Том 10 харилцагчийн хадгаламж, харилцахын төвлөрлийн харьцаа	<25%	8.0%
2.3.	<i>Үнэт цаас гаргагчийн үйл ажиллагаанд гадаад, дотоод орчноос үзүүлж буй нөлөөлөл, үйл ажиллагаа явуулж буй салбарт эзлэх хувь, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрөлд гарч буй өөрчлөлт, хөгжил дээрх өөрчлөлтөд үнэт цаас гаргагчийн зүгээс авч хэрэгжүүлэхээр төлөвлөж буй арга хэмжээний мэдээлэл</i>	Гадаад хүчин зүйлс: 2025 онд Монгол Улсын эдийн засаг 6.8 хувиар өсөв. Энэхүү өсөлтөд хөдөө аж ахуйн салбарын өсөлт гол нөлөөг үзүүлсэн ба аж үйлдвэр, барилгын салбарын идэвхжил өндөр байлаа. Харин уул уурхайн салбарын хувьд дэлхийн зах зээл дээрх коксжих нүүрсний үнийн бууралт болон газрын тос, нүүрсний олборлолтын хэмжээ буурсан нь тус салбарын өсөлт саарахад нөлөөлсөн хэдий ч зэсийн үнийн өсөлт, Оюу толгойн гүний уурхайн олборлолт нэмэгдсэнээр тус салбар 2025 онд 10.6 хувиар өслөө. Эдийн засгийн өсөлтийг салбараар авч үзвэл хөдөө аж ахуйн салбар 2.9 нэгж хувиар, уул уурхайн салбар 1.4 нэгж хувиар, барилга, үйлчилгээ, үйлдвэрлэлийн салбарууд 2.0 нэгж хувиар эдийн засгийн өсөлтөд хувь нэмэр оруулсан бол худалдаа салбар 0.6 нэгж хувиар эдийн засгийн өсөлтийг сааруулсан байна. Монголбанк болон Олон Улсын Байгууллагууд Монгол улсын 2026 оны эдийн засгийн өсөлт 5.5%-6.0% хүрэх төсөөллийг хийгээд байна. Ирэх онд экспортын голлох бүтээгдэхүүн болох нүүрсний эрэлт сул байх төлөвтэй байгаа хэдий ч Оюутолгойн гүний уурхайн олборлолт эрчимжсэнээр зэсийн баяжмалын олборлолт үргэлжлэн өсөж, уул уурхайн салбарын өсөлтийг дэмжих хүлээлтийг бий болгож байна. Нүүрсний экспортын хэмжээ 89.7 сая тоннд хүрч, өмнөх оны эцсээс өссөн хэдий ч дэлхийн зах зээл дээрх нүүрсний үнийн уналтаас шалтгаалан нүүрсний экспортын орлого нь 3.0 тэрбум ам.доллараар буурсан байна. Гэсэн хэдий ч 2025 онд экспортолсон зэсийн тоо хэмжээ 35 хувиар нэмэгдсэнээс гадна дэлхийн зах зээл дээр үнэ нь өссөнөөр зэсийн экспортын орлого 5,809 сая ам.долларт хүрсэн байна. Улмаар гадаад худалдааны тэнцэл өмнөх оны мөн үеэс 221 сая ам.доллараар өсөж, 4,389 сая ам долларт хүрлээ. 2025 онд төлбөрийн тэнцэл өмнөх оны эцсээс 412 сая ам.доллараар өсөж, улмаар 1,034 сая ам.долларын ашигтай гарсан ба санхүүгийн данс 3,321 сая ам.долларын ашигтай гарсан нь төлбөрийн тэнцэл ашигтай гарахад гол нөлөөг үзүүлсэн байна.		

		Үүний үр дүнд гадаад валютын албан нөөц 12 дугаар сарын эцсийн байдлаар 7.0 тэрбум ам.долларт хүрч, оны эхнээс 27.1 хувиар өссөн байна. Ийнхүү төлбөрийн тэнцэл ашигтай байж, ГВАН өссөн нь ам.долларын ханш 2026 оны турш тогтвортой байх суурь нөхцөл боллоо. 2025 оны эхний хагаст инфляц саарах хандлага ажиглагдсан ч хүнсний гол нэрийн бүтээгдэхүүн болох мах, хүнсний ногооны үнийн өсөлтийн нөлөөгөөр 10 дугаар сард 9.2 хувьд хүрч нэмэгдсэн байна. Харин оны сүүлийн хоёр сард төрийн зохицуулалттай үйлчилгээ болох цахилгаан, дулааны үнийн өсөлтийн суурь нөлөө буурснаар инфляц бага зэрэг саарч, оны эцэст 7.5 хувьд хүрч, Монголбанкны зорилтот түвшинд хадгалагдлаа. 2025 онд тариалангийн бүс нутгуудад хур тунадас бага, хэт халалттай байснаас шалтгаалан ургацын хэмжээ өнгөрсөн оноос бага байсан нь ирэх онд хүнсний инфляц нэмэгдэх хүлээлтийг бий болгож байна. Түүнчлэн 2026 онд боловсрол, эрүүл мэндийн салбарын ажилчдын цалинг нэмэгдүүлэхээр төлөвлөж байгаа нь инфляц өсөх хүлээлтийг улам нэмэгдүүлж байна. 2025 онд Монголбанк нь Мөнгөний бодлогын хороог 7 удаа хуралдуулсан бөгөөд 01 дүгээр сарын хурлаар бодлогын хүүг 2 нэгж хувиар өсгөснөөр 12 хувьд хүргэсэн ба түүнээс хойш энэ түвшинд хадгалаад байна. Дотоод хүчин зүйлс: Олон улсын зээлжих зэрэглэлийн Moody’s Ratings агентлаг Монгол Улсын зээлжих зэрэглэлийг сайжруулахтай зэрэгцэн ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэлийг мөн B2-оос B1 (тогтвортой) болгон нэг шат ахиулсан бол Fitch Ratings агентлаг ХасБанкны урт хугацааны зээлжих зэрэглэлийг B+ түвшинд дахин баталгаажууллаа. Харилцагч болон хөрөнгө оруулагч нартаа зориулан мэдээллийг илүү хялбар, ойлгомжтой байдлаар хүргэх зорилгоор эмх цэгцтэй, орчин үеийн шинэлэг дизайны шийдэл бүхий Банкны вэбсайтыг ахин загварчлалаа. Олон улсын мэргэжлийн байгууллага болох Дотоод Аудитын Институт (IIA)-ээр дотоод аудитын үйл ажиллагаандаа үнэлгээ хийлгэлээ. Банк зөвхөн үнэлгээ хийлгээд зогсохгүй, дотоод аудитын үйл ажиллагаандаа шинэ аргачлал болон датанд суурилсан хяналтын цогц шийдлийг хэрэгжүүлэхээр боллоо. Санхүүгийн Зохицуулах Хорооны зөвшөөрлийн дагуу ХасБанкны толгой компани болох Тэнгэр Санхүүгийн Нэгдэл (ТСН) ХХК-ийг ХасБанканд нэгтгэх хэлбэрээр компанийг өөрчлөн байгууллаа. Ийнхүү бид хувьцаа эзэмшлийн хэт төвлөрлөөс зайлсхийж, засаглалын зөв бүтэц зохион байгуулалтыг бий болгосноор Банкны тухай хуулийн 36.1 дугаар заалтын дагуу нэг хувьцаа эзэмшигч 20 хувиас илүүгүй байх шаардлагыг албан ёсоор хангаж буй системийн хэмжээний анхны банк боллоо. Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банкны синдикат зээлийн санхүүжилтийн хүрээнд ХасБанк нь 35 хүртэлх насны залуу бизнес эрхлэгчдийг дэмжих, тэдний бизнесийн өсөлт хөгжил, тогтвортой байдлыг бэхжүүлэх зорилгоор “Залуу бизнес эрхлэгчийн зээл” бүтээгдэхүүнийг харилцагчдадаа санал болгов. Тус зээл нь бизнесээ эхлүүлэх, үйл ажиллагааны цар хүрээг нэмэгдүүлэх, шинэ техник, тоног төхөөрөмж худалдан авах, эргэлтийн хөрөнгийн хэрэгцээг
--	--	---

		хангах, зах зээлд өрсөлдөх чадварыг сайжруулах зэрэг олон талт санхүүгийн хэрэгцээг цогцоор шийдвэрлэхэд чиглэгдсэн бөгөөд энэхүү хүүгийн уян хатан нөхцөлтэй санхүүжилтийн боломжийг бүрдүүлснээр залуу бизнес эрхлэгчдийн урт хугацааны тогтвортой өсөлтийг дэмжихэд онцгой ач холбогдолтой юм. ТУЗ-ийн шийдвэр болон зохицуулагч байгууллагуудаас өгсөн зөвшөөрлийн дагуу жижиг хувьцаа эзэмшигчдийнхээ хувьцааны хөрвөх чадварыг нэмэгдүүлэх зорилгоор нээлттэй зах зээлд гаргасан хувьцааны тодорхой хэсгийг эргүүлэн худалдан авч халааслах хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж байна.									
2.4.	Санхүүгийн байдлын тайлангийн гадуур бүртгэгдсэн ажил, гүйлгээний талаарх дэлгэрэнгүй мэдээлэл, нягтлан бодох бүртгэлийн бодлогын мэдээлэл /off balance/	ХасБанкны 2025 оны тэнцлийн гадуурх дансны үлдэгдлийн тайланг Хавсралт №2-д оруулав.									
2.5.	Тайлант хугацаанд авсан зээлийн эргэн төлөлт болон зээлийн барьцаа, баталгааны талаарх мэдээлэл	2025 онд нийт 272.5 сая ам.долларын урт хугацаат санхүүжилтийг гадаадын санхүүгийн байгууллагуудаас татан төвлөрүүлсэн бол нийт 173.7 сая ам.долларын гадаад эх үүсвэрийн эргэн төлөлтийг хийсэн байна.									
3.	Үнэт цаас гаргагчийн тайлант хугацаанд хийгдсэн сонирхлын зөрчилтэй болон их хэмжээний хэлцлийн мэдээлэл, хэлцэл хийх ач холбогдол зорилго, сонирхлын зөрчилтэй этгээдийн талаарх мэдээлэл /тайлант хугацаанд хийгдсэн нийт сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг тусгана/										
Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь өөрийн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд зөвхөн харилцагчид санал болгох нөхцөлтэй ижил нөхцөлөөр үйлчилгээ үзүүлж байна. Иймд, хэрэв тухайн нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдэд олгосон нийт зээлийн хэмжээ 300.0 сая төгрөгөөс бага бол (орон сууцны зээлийн тухайд 200.0 сая төгрөгөөс бага бол) тухайн этгээдэд ердийн журмаар зээл олголт хийгдэх бөгөөд ийнхүү шийдвэрлэгдсэн хэлцлүүдийг улирал бүр Төлөөлөн удирдах зөвлөл (“ТУЗ”) хянан үзэж батламжилдаг. Харин, дээрх дүнгээс их, эсхүл харилцагчийн нөхцөлөөс өөр нөхцөлтэй тохиолдолд зөвхөн ТУЗ урьдчилан хянаж баталснаар үйлчилгээ үзүүлнэ. ТУЗ-ийн эрсдэлийн удирдлагын хороо нэгдмэл сонирхолтой этгээд болон тэдгээрийн холбогдох этгээдийн хэлцэлд хяналт тавин, ТУЗ-өөр ийнхүү тухай бүр шийдвэрлүүлдэг ба ингэхдээ, Банкны тухай хуулийн 17.9-д заасан шаардлага буюу банкны ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлгүй байх шаардлагыг баримтлан ажиллаж байна. Холбогдох этгээдийн болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн талаарх мэдээллийг банкны өөрийн болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр олон нийтэд мэдээлдэг. Дараах холбоосоор орж танилцана уу. https://xacbank.mn/ad-hoc https://mse.mn/mn/company/568 Түүнчлэн, Банкны холбогдох этгээдэд олгосон зээл, зээлтэй адилтган тооцох бусад актив хөрөнгийн тайланг улирал бүр гарган өөрийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлдэг. Тус тайлантай дараах холбоосоор орж танилцана уу. https://xacbank.mn/financial-highlights ТУЗ-өөс 2025 онд нийт 12 сонирхлын зөрчилтэй болон холбогдох этгээдийн хэлцлийг батламжилсан/байгуулах зөвшөөрөл олгосон. Үүнд:											
<table><tr><th>№</th><th>Хамаарал</th><th>Хэлцлийн дүн (төгрөг)</th></tr><tr><td>1</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>50,000,000</td></tr><tr><td>2</td><td>Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд</td><td>50,000,000</td></tr></table>			№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)	1	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000	2	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
№	Хамаарал	Хэлцлийн дүн (төгрөг)									
1	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000									
2	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000									

3	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
4	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
5	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	50,000,000
6	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	400,000
7	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	400,000
8	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	16,000,000
9	Банкны эрх бүхий албан тушаалтан	468,321,000
10	Банкны эрх бүхий албан тушаалтны холбогдох этгээд	149,000,000
11	Банкны хувьцаа эзэмшигчийн холбогдох этгээд	50,000,000
12	Банкны эрх бүхий албан тушаалтан	195,000,000

Тайлант хугацаанд их хэмжээний хэлцэл хийгдээгүй болно.

4. Цалин урамшууллын мэдээлэл

Банкны цалин, урамшуулал, нөхөн олговрын мэдээллийг Аудитлагдсан санхүүгийн тайлангийн 10-р тодруулгад толилуулсан бөгөөд тайлант хугацааны нийт боловсон хүчний зардал 93,4 тэрбум төгрөг буюу өмнөх онтой харьцуулахад 2.8 хувь буурсан байна.

Аудитлагдсан санхүүгийн тайланг харах холбоос:

<https://www.xacbank.mn/page/audited-report>

1. ТУЗ-ийн гишүүдийн цалин, урамшуулал

ТУЗ-ийн гишүүний хөлсний хэмжээг хувьцаа эзэмшигчдийн хурлаар тогтоодог. ТУЗ-ийн гишүүд ТУЗ, ТУЗ-ийн дэргэдэх хорооны хуралд оролцох болон холбогдох бусад үүрэг хариуцлагыг гүйцэтгэхтэй холбоотой хөлс авдаг ба энэ нь түүний оролцох шаардлагатай ТУЗ, түүний хороо болон хувьцаа эзэмшигчдийн хурлын ирцээс хамааран тодорхойлогдоно. Хөлсийг улирал тутамд олгоно. Банканд давхар албан тушаал хашдаггүй ТУЗ-ийн гишүүн хувьцаа эзэмшигчдээс тогтоосон хөлс, хороо удирдсантай холбогдуулан олгох нэмэгдлээс өөр бусад хөлс, шагнал урамшуулал авдаггүй.

ТУЗ-ийн гишүүний хөлсийг 2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар шинэчлэн тогтоосон. Тогтоолтой Монголын хөрөнгийн бирж болон ХасБанкны цахим хуудаст хандан танилцах боломжтой.

2025 оны 12 сарын 31-ний байдлаарх ТУЗ-ийн гишүүдийн ХасБанк дахь хувь эзэмшил:

№	Овог нэр	Албан тушаал	Хувь эзэмшил (шууд)
1	Санжай Гүпта	ТУЗ-ийн дарга	0.08%
2	Анджей Витак	ТУЗ-ийн гишүүн	-
3	Доминик Жак	ТУЗ-ийн гишүүн	-
4	Майкл Мадден	ТУЗ-ийн гишүүн	-
5	Сюзанна Карр	ТУЗ-ийн гишүүн	-
6	Г.Цэвэгжав	ТУЗ-ийн гишүүн	0.28%
7	Н.Цэлмүүн	ТУЗ-ийн гишүүн	-
8	Нираж Вэдва	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
9	Стюарт Холл	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
11	Б. Уламбаяр	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-
11	Эми Чой	ТУЗ-ийн хараат бус гишүүн	-

2. Гүйцэтгэх захирлын цалин урамшуулал

Гүйцэтгэх захирлын цалин хөлс нь үндсэн цалин, жилийн гүйцэтгэлд суурилсан урамшууллаас бүрдэнэ. Засаглал, цалин урамшууллын хороо (хуучнаар Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо. Тус хороо нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр 2025 оны 04 дүгээр сарын 30 өдөр “Нэр дэвшүүлэх хороо” болон “Засаглал, цалин урамшууллын хороо” хэмээх хоёр бие даасан хороонд хуваагдсан болно.)-оос гаргасан Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан зөвлөмжид үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийнэ. Банкны стратегийн зорилго, гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтэд тулгуурласан энэхүү үнэлгээ нь түүнд олгох цалин хөлсийг тодорхойлох үндэслэл болно.

Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын гүйцэтгэлийг ТУЗ болон Засаглал, цалин урамшууллын хороо хэлэлцээд түүнд олгох 2025 оны гүйцэтгэлд суурилсан урамшууллыг баталсан.

Мөн ХасБанк ХК нь байгууллагын дотоод хөтөлбөр, хүний нөөцийн үндсэн бодлогын хүрээнд ур чадвар бүхий удирдах албан тушаалтныг тогтоон барих, урамшуулах, банкны залгамж халааг бэлдэх зорилгоор гүйцэтгэлд суурилсан урт хугацаат урамшууллын хөтөлбөрийг хэрэгжүүлдэг.

Гүйцэтгэх удирдлагын ХасБанканд эзэмшиж буй хувьцааны хувь эзэмшлийг дээр дурдсан хөтөлбөрийн хүрээнд эзэмшүүлсэн хувьцааг оролцуулан 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар толилуулав:

№	Овог нэр	Албан тушаал	Хувь эзэмшил (шууд)
1	Г.Цэвэгжав	Гүйцэтгэх захирал	0.28%
2	Г.Эрдэнэбаяр	Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал	0.10%
3	Б.Еркин	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал	0.06%
4	С.Дауренбек	Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнесийн банк хариуцсан захирал	0.06%
5	Д.Мөнхзул	Лизинг хариуцсан захирал	0.02%
6	Г.Тамир	Санхүү хариуцсан захирал	0.01%
7	Илия Аврамов	Эрсдэл хариуцсан захирал	0.00%
8	Э.Ундармаа	Зээл хариуцсан захирал	0.04%
9	Г.Зул	Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал	0.06%
10	Э.Уламбаяр	Үйл ажиллагаа хариуцсан захирал	0.07%
11	Х.Өнөрбат	Мэдээллийн технологи хариуцсан захирал	0.04%
12	Н.Мөнхцэлмэг	Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	0.02%
13	Б.Биндэрьяа	Ерөнхий аудитор	0.01%

5. Компанийн засаглалтай холбоотой мэдээлэл

1. Төлөөлөн удирдах зөвлөл ("ТУЗ")

ХасБанкны Дүрмийн дагуу ТУЗ нь 12 гишүүний бүрэлдэхүүнтэй. ТУЗ-ийн гишүүд:

					
Санжай Гүпта ТУЗ-ийн дарга	Г.Цэвэгжав ТУЗ-ийн гишүүн	Н.Цэлмүүн ТУЗ-ийн гишүүн	Майкл Мадден ТУЗ-ийн гишүүн	Доминик Жак ТУЗ-ийн гишүүн	Анджей Витак ТУЗ-ийн гишүүн
					
*Албертус Браггинк ТУЗ-ийн гишүүн (2025.10.01-ний өдрөөс эхлэн өөрийн хүсэлтээр огцорсон)	Сюзанна Херринг Карр ТУЗ-ийн гишүүн	Б.Уламбаяр ТУЗ-ийн хараат бус гишүүн	Нираж Вэдва ТУЗ-ийн хараат бус гишүүн	Эми Чой ТУЗ-ийн хараат бус гишүүн	Стюарт Доналд Холл ТУЗ-ийн хараат бус гишүүн

Жич: Гишүүдийн боловсрол, ажлын туршлага зэрэг дэлгэрэнгүй мэдээлэлтэй банкны вэбсайтаар дамжуулан танилцах боломжтой.

2025 оны 09 дүгээр сарын 30-ны өдрийн R-2025-42 дугаар тогтоолоор ТУЗ-ийн гишүүн Албертус Браггинк нь үүрэгт ажлаасаа чөлөөлөгдөх хүсэлт ирүүлснийг ТУЗ хүлээн авснаар 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал ТУЗ 11 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаа явуулав.

2. Гүйцэтгэх удирдлагын баг

Тайлант хугацаанд ХасБанк нь дараах удирдлагын бүрэлдэхүүнтэйгээр үйл ажиллагаагаа удирдан зохион байгуулсан:

				
Гүмэнжавын Цэвэгжав Гүйцэтгэх захирал	Ганзоригийн Эрдэнэбаяр Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирал	Бавааны Еркин Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Байгууллагын банк хариуцсан захирал	Серикжаны Дауренбек Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнесийн банк хариуцсан захирал	Доржпүрэвийн Мөнхзул Лизинг хариуцсан захирал
				
Ганхуягийн Тамир Санхүү хариуцсан захирал	Илия Аврамов Эрсдэл хариуцсан захирал	Энхбаярын Ундармаа Зээл хариуцсан захирал	Ганзоригийн Зул Хүний нөөц, захиргаа хариуцсан захирал	Энэбишийн Уламбаяр Үйл ажиллагаа хариуцсан захирал
				
Хүрэлбаатарын Өнөрбат Мэдээллийн технологи хариуцсан захирал	Нямсүрэнгийн Мөнхцэлмэг Хууль хариуцсан захирал / ТУЗ-ийн нарийн бичгийн дарга	Баттогтохын Биндэрьяа Ерөнхий аудитор		

Тайлант хугацаанд гүйцэтгэх удирдлагын бүрэлдэхүүнд дараах өөрчлөлт орсон:

Удирдлагын багт орсон өөрчлөлт

Банкны Гүйцэтгэх захирлын 2025 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн А-1294 тоот тушаалын дагуу ХасБанк ХК-ийн бүтэц зохион байгуулалтад дараах өөрчлөлтүүд орсон болно:

1. Санхүү хариуцсан захирлын албан тушаалд Г.Тамирыг шинээр томилох;
2. Гүйцэтгэх захирлын тэргүүн орлогч бөгөөд Иргэдийн банк хариуцсан захирлын албан тушаалд Г.Эрдэнэбаяр;
3. Үйл ажиллагаа хариуцсан захирлын албан тушаалд Э.Уламбаяр;
4. Хүний нөөц, Захиргаа хариуцсан захирлын албан тушаалд Г.Зул;
5. Гүйцэтгэх захирлын орлогч бөгөөд Бизнесийн банк хариуцсан захирлын албан тушаалд С.Дауренбек нарыг тус тус шилжүүлэн ажиллуулахаар томилсон болно.

Энэ талаар 2025 оны 12 дугаар сарын 02-ны өдөр Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан нийтэд мэдээлсэн.

3. ТУЗ-ийн үйл ажиллагааны цахимжуулалт

ТУЗ-ийн үйл ажиллагааг цахимжуулж, мэдээллийн аюулгүй байдлыг хангах, дотоод мэдээллийн хяналт хадгалалт, дамжуулалтыг сайжруулах зорилгоор 2025 онд NASDAQ-ын BoardVantage платформыг үйл ажиллагаандаа бүрэн нэвтрүүлэн ашиглаж байна. Уг платформын тусламжтайгаар ТУЗ-ийн гишүүдэд мэдээллийг мэйлээр бус платформоор дамжуулан хүргэж, ТУЗ-ийн гишүүд “watermark” бүхий хамгаалалттай бичиг баримтуудыг хүлээн авснаар дотоод мэдээллийн аюулгүй байдал сайжирсан болно. Түүнчлэн, цахимаар

санал өгөх үйл явц илүү хялбар, ойлгомжтой болсноос гадна, саналын үр дүнг тусгасан тайланг платформоос автоматаар татаж авах боломжтой болсон.

4. ТУЗ болон түүний дэргэдэх хороодын хурал

ХасБанкны ТУЗ нь 2025 онд 4 удаагийн ээлжит, 4 удаагийн ээлжит бус хурал болон 8 цахим санал хураалтыг оролцуулан нийт 16 удаа хуралдаж, нийт 55 тогтоол шийдвэрийг гаргаж ажилласан байна. ТУЗ-ийн ээлжит хурал тус бүрээр ТУЗ-ийн хурлын өмнөх шийдвэр, зөвлөмжийн дагуу авсан арга хэмжээний талаарх мэдээллийг ТУЗ-д танилцуулдаг.

2025 оны 2 дугаар улирал хүртэлх хугацаанд буюу ТУЗ-ийн дэргэдэх Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо (хуучин бүтцээр. Холбогдох тайлбарыг хороодын танилцуулга хэсгээс харна уу) 3 удаа хуралдсан байна. Хоёрдугаар улирлаас хойш 2025 онд Засаглал, цалин урамшууллын хорооны хурал 2 удаа, Нэр дэвшүүлэх хорооны хурал 3 удаа, Эрсдэлийн удирдлагын хорооны хурал 5 удаа, Аудитын хорооны хурал 5 удаа тус бүр хуралдаж, ТУЗ-д холбогдох зөвлөмж гаргаж ажилласан байна.

5. ТУЗ-ийн дэргэдэх хороодын чиг үүрэг

Тайлант хугацаанд ТУЗ-ийн дэргэдэх хороод дараах бүрэлдэхүүнтэй ажилласан:

Аудитын хороо ("АХ")	Нэр дэвшүүлэх хороо ("НДХ")	Эрсдэлийн удирдлагын хороо ("ЭУХ")	Засаглал, цалин урамшууллын хороо ("ЗЦУХ")
Дарга: Б.Уламбаяр	Дарга: Стюарт Холл	Дарга: Доминик Жак	Дарга: Майкл Мадден
Ердийн гишүүд: Анджей Витак Сюзанна Карр	Ердийн гишүүн: Сюзанна Карр Доминик Жак	Ердийн гишүүн: Майкл Мадден	Ердийн гишүүн: Н.Цэлмүүн
Хараат бус гишүүд: Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл	Хараат бус гишүүд: Б.Уламбаяр Нираж Вэдва Эми Чой Стюарт Холл

Засаглал, нэр дэвшүүлэх, цалин урамшууллын хороо нь Хувьцаа эзэмшигчдийн хурал, ТУЗ-ийн шийдвэрээр 2025 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс чиг үүргийн дагуу "Нэр дэвшүүлэх хороо" болон "Засаглал, цалин урамшууллын хороо" хэмээх хоёр бие даасан хороонд хуваагдсан. ТУЗ-ийн дэргэдэх хороод дараах үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна:

(i) Засаглал, цалин урамшууллын хороо

Засаглал, цалин урамшууллын хороо нь компанийн засаглалын үр нөлөөтэй тогтолцоог бүрдүүлж, удирдлагын цалин хөлсний бүтэц, бодлогод хяналт тавих үүрэгтэй. Уг хороо нь Гүйцэтгэх захирал болон түлхүүр ажилтнуудын цалин урамшууллыг банкны стратегийн зорилт, эрсдэлийн удирдлагын тогтолцоо болон хувьцаа эзэмшигчдийн урт хугацааны ашиг сонирхолд нийцүүлэх, банкны дотоод засаглалын тогтолцоо, эрх бүхий албан тушаалтны ёс зүй болон ашиг сонирхлын зөрчлийг удирдан хянах, холбогдох бодлого журам, үнэлгээ, сургалт, сайжруулалтын асуудлыг хууль тогтоомж, зохицуулагч байгууллагын шаардлага болон олон улсын сайн туршлагад нийцүүлэн хянах, ТУЗ-д санал, зөвлөмж хүргүүлэх чиг үүргийг хэрэгжүүлж байна.

(ii) Нэр дэвшүүлэх хороо

Нэр дэвшүүлэх хороо нь ТУЗ-ийн бүрэлдэхүүний олон талт, үр нөлөөтэй байдлыг хангаж, удирдлагын залгамж халааг бэлтгэх асуудлаар ТУЗ-д дэмжлэг үзүүлэх үүрэгтэй. Уг хороо нь ТУЗ-ийн гишүүн болон Гүйцэтгэх захирлын албан тушаалд сонгогдон томилогдох мэргэжлийн ур чадварыг хангасан нэр дэвшигчдийг тодорхойлох, үнэлэх, санал болгох, түүнчлэн

байгууллагын урт хугацааны тогтвортой хөгжлийг хангах үүднээс ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын залгамж халааны төлөвлөлтийн талаар зөвлөмж, мэдээллээр хангах үндсэн үүрэг хариуцлагыг ханган ажиллаж байна.

(iii) Эрсдэлийн удирдлагын хороо

Эрсдэлийн удирдлагын хороо нь эрсдэлийн удирдлага дотоод хяналтын зохистой тогтолцоог бүрдүүлж, эрсдэлтэй холбоотой асуудлаар ТУЗ-д зөвлөмж гаргах үүрэгтэй. Уг хороо нь эрсдэлийн удирдлагын бодлого, бизнесийн чиглэл бүрийн материаллаг эрсдэлийг бууруулах зохистой төлөвлөгөө, эрсдэлийн удирдлагын чиг үүрэг үр дүнтэй байгаа эсэх, эрсдэл хүлээх хязгаар, зээлийн багцын чанар, зээлийг батлах эрх мэдэл, зээлийг сангаас хаах зэрэг асуудлаар ТУЗ-д зөвлөх, түүнчлэн ТУЗ-өөс эрх шилжүүлсний дагуу зарим шийдвэр гаргах зэрэг үндсэн үүрэг хариуцлагатай.

(iv) Аудитын хороо

Аудитын хороо нь дотоод хяналтын системийн бүрэн бүтэн, зөв зохистой болон үр дүнтэй байдлыг хянах үүрэгтэй. Уг хороо нь хөндлөнгийн аудиторыг томилох, дахин томилох эсвэл чөлөөлөх, дотоод аудитын газрын ажлын гүйцэтгэл, санхүүгийн тайлагналын шаардлага, заалтуудыг мөрдөж буй эсэх, аудитлагдсан болон аудитлагдаагүй жилийн ба хагас жилийн санхүүгийн тайланг нягталж хянах, ердийн бус хэлцлийг хянах, хууль тогтоомжийн өөрчлөлт ба санхүүгийн тайланд үзүүлэх нөлөөг хянах үндсэн үүрэг хариуцлагатай. Аудитын хороо нь Ерөнхий аудиторыг томилдог ба түүний ажлын гүйцэтгэлийг үнэлдэг.

6. ТУЗ-өөс баталсан бодлого, журам

ХасБанк нь Компанийн тухай хуульд заасан хувьцаат компанийн тусгай зохицуулалтууд, Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн актууд, Компанийн засаглалын кодексийн шаардлагад нийцүүлэн 2025 онд нийт 18 дүрэм, журам, бодлогыг шинээр батлах, нэмэлт өөрчлөлт оруулах, шинэчлэн батлах байдлаар дотоод эрх зүйн орчноо сайжруулсан. Үүнд:

Шинээр баталсан:	Нэмэлт, өөрчлөлт оруулсан:
1. Залилангийн эсрэг ерөнхий журам; 2. Нэр дэвшүүлэх хорооны дүрэм; 3. Засаглал, цалин урамшууллын хорооны дүрэм	1. ХасБанкны дүрэм; 2. ТУЗ-ийн үйл ажиллагааны журам; 3. Гүйцэтгэх удирдлагын залгамж халааг бэлдэх бодлого; 4. Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журам; 5. ХасБанкны засаглалын кодекс; 6. ТУЗ-ийн үнэлгээний журам; 7. ХасБанкны ногдол ашгийн бодлого; 8. Дотоод аудитын дүрэм; 9. ТУЗ-ийн дэргэдэх Аудитын хорооны дүрэм
	Шинэчлэн баталсан: 1. ТУЗ-ийн гишүүнийг сонгон шалгаруулах, нэр дэвшүүлэх, түүний залгамж халааг бэлдэх ерөнхий журам; 2. Эрсдэлийн удирдлагын нэгдсэн бодлого; 3. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх дотоод хяналтын хөтөлбөр; 4. Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны журам; 5. Харилцагчийг таньж мэдэх журам

6. Ёс зүйн кодекс, сонирхлын зөрчил ба толилуулга

Банкны ёс зүйн хэм хэмжээ нь чин сэтгэлээсээ байх, үнэнч байх, шударга байх, ил тод байх зарчмуудад үндэслэдэг. ХасБанк нь хууль ёсны бөгөөд ёс зүйтэй бизнесийн үйл ажиллагаа явуулах, дотооддоо ёс зүйт зан үйлийн дээд стандартыг баримтлан “ТУЗ-ийн гишүүд болон

	ажилтнуудын ёс зүйн кодекс ба сонирхлын зөрчлийн ерөнхий журам”-ыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна. ТУЗ-ийн болон гүйцэтгэх удирдлагын бүх гишүүд өөрийн холбогдох этгээдийн мэдээллийг өөрчлөлт орох тухай бүр мэдэгдэхээс гадна <u>жилд 2 удаа</u> бататгах толилуулгын хуудсыг үйлдэж, сонирхлын зөрчил үүсэж болзошгүй нөхцөл байдлыг урьдчилан тогтоох боломжийг ханган ажиллаж байна. Мөн түүнчлэн, ТУЗ-ийн гишүүд ТУЗ-ийн хурал эхлэхэд, мөн хурлын туршид хэлэлцэх асуудалтай холбоотой аливаа сонирхлын зөрчил байвал түүнийгээ мэдэгддэг ба Компанийн тухай хуулийн дагуу уг гишүүн санал хураалтад оролцдоггүй. ХасБанк нь “Сонирхлын зөрчилтэй этгээд болон холбогдох этгээдтэй хэлцэл хийх журам”-ыг баримтлан өөрийн ердийн үйл ажиллагааны хүрээнд бусад этгээдтэй хийх хэлцлээс хөнгөлөлттэй нөхцөлөөр сонирхлын зөрчилтэй этгээдтэй хэлцэл хийх, улмаар хувьцаа эзэмшигчдийн нийтлэг ашиг сонирхол зөрчигдөхөөс сэргийлэн ажиллаж байна. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 56 дугаар зүйлийн 56.2.4 дэх заалтад заасны дагуу ХасБанк нь холбогдох этгээд болон сонирхлын зөрчилтэй хэлцлийн мэдээллийг банкны өөрийн цахим хуудсаар болон Монголын хөрөнгийн биржийн цахим хуудсаар дамжуулан олон нийтэд мэдээлж ажиллаж байна. 7. Дотоод аудитын ажлын тайлан Аудитын хороо нь улирал тутам хуралдаж, батлагдсан төлөвлөгөөний дагуу хийгдсэн аудитын тайлангууд, баримт бичгийн нэмэлт өөрчлөлт, холбоотой талуудын мэдээллийн датабаазын мэдээ болон хөндлөнгийн аудитын тайлан мэдээллийг хэлэлцүүлж, ТУЗ-ийн хуралд тайлагнан ажиллаж байна. 8. Гүйцэтгэх захирлын ажлын тайлан ТУЗ нь Гүйцэтгэх захирлын гэрээний нөхцөл болзол, ажлын гүйцэтгэлийн талаар гаргасан Засаглал, цалин урамшууллын хорооны зөвлөмжийг үндэслэн Гүйцэтгэх захирлын ажлын гүйцэтгэлд жил бүр үнэлгээ хийдэг. Үүний дагуу ТУЗ нь Гүйцэтгэх захирлын 2025 оны ажлын гүйцэтгэлийг 2026 оны 03 дугаар сарын 04-ний өдөр хэлэлцээд, бодит гүйцэтгэлийг 96.9% гэж үнэлсэн болно. 9. Компанийн засаглалын кодексийн хэрэгжилтийн үнэлгээ Санхүүгийн зохицуулах хороо (“СЗХ”)–оос баталсан Компанийн засаглалын кодекс-ийн удирдамжийн үнэлгээний аргачлалын дагуу ХасБанкны “Компанийн засаглалын кодексийн хэрэгжилт”-ийн 2024 оны жилийн эцсийн тайланг СЗХ-ноос хянан баталгаажуулж 93.1% буюу засаглал сайн, эрсдэлгүй гэж үнэлсэн. 2025 оны жилийн эцсийн үнэлгээ хараахан гараагүй байгаа тул тухайн оны хагас жилийн тайлангийн үнэлгээг танилцуулбал, 95.8% буюу мөн засаглал сайн, эрсдэлгүй гэсэн үнэлгээтэй байна. Тайлантай Монголын хөрөнгийн бирж болон банкны цахим хуудсаар дамжуулан танилцах боломжтой. 10. Банкны оролцогч талуудтай харилцах харилцаа ХасБанк нь хувьцаа эзэмшигчтэй тусгай дугаар (8508-1888) болон цахим шуудан (investor-relations@xacbank.mn)-аар дамжуулан харилцдаг бөгөөд ийнхүү харилцахдаа Хувьцаа эзэмшигчидтэй шууд харилцах ерөнхий журам болон Оролцогч талуудтай харилцах, хамтран ажиллах журмыг мөрдлөг болгон ажилладаг. 11. Мэдээллийн ил тод байдал ХасБанк нь өөрийн хувьцаа эзэмшигчид болон эрх бүхий байгууллагуудад банкны талаарх мэдээллийг холбогдох хууль тогтоомжид заасан шаардлагын дагуу ил тод тайлагнан, мэдээлэх зорилгоор Мэдээллийг ил тод болгох ерөнхий журмыг үйл ажиллагаандаа мөрдөн ажиллаж буй бөгөөд, ТУЗ түүний хэрэгжилтэд хяналт тавьдаг.
6.	<i>Зах зээлийн эрсдэлийн мэдээлэл</i> Банкны эрсдэлийн удирдлагын нэгж нь Төлөөлөн Удирдах Зөвлөл (ТУЗ)-ийн дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороо (ЭУХ)-д улирал бүр, гүйцэтгэх удирдлагын дэргэдэх Эрсдэлийн Удирдлагын Хороо (ЭУХ)-д сар бүр Нэгдсэн Эрсдэлийн Тайлан, холбогдох эрсдэлийн шинжилгээг танилцуулж, шаардлагатай шийдвэрүүдийг гаргаж хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний биелэлтэд хяналт тавьж ажилладаг. Хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг

	банкны бизнес төлөвлөгөө, стратегитэй уялдуулан жил бүр ТУЗ-ийн дэргэдэх ЭУХ-р шинэчлэн батлуулж, үйл ажиллагаандаа мөрдөн хэрэгжүүлдэг. 2025 онд Банк нь зах зээлийн гол хувьсагчид болох хүү, гадаад валютын ханш, үнийн хэлбэлзлээс үүдэх эрсдэлийг үнэлж, санхүүгийн хэрэгслүүдийн үнэ цэнэ болон мөнгөн урсгалд учирч болзошгүй нөлөөллийг хүлээн зөвшөөрөх эрсдэлийн түвшинд удирдсан. Түүнчлэн зохицуулагч байгууллагаас тогтоосон санхүүгийн болон санхүүгийн бус эрсдэлийн бүхий л үзүүлэлтүүдийн хувьд хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээний хязгаарын хүрээнд тогтмол хангаж ажиллаа. ХасБанк нь 2023 оноос эхлэн Базел III олон улсын жишгийн дагуу өөрийн хөрөнгийн хүрэлцээг дотооддоо үнэлэх ICAAP (Internal Capital Adequacy Assessment Process) болон хөрвөх чадварын хүрэлцээг дотооддоо үнэлэх ILAAP (Internal Liquidity Adequacy Assessment Process) аргачлалуудыг боловсруулж, жил бүр үнэлгээг хийж банкны эрсдэлийн нэгдсэн удирдлага болон стратеги төлөвлөлтөдөө нэвтрүүлэн ашиглаж байна. Хөрвөх чадварын эрсдэлийн удирдлагын хүрээнд Банк нь хөрвөх чадварын нөөц (liquidity buffer), богино хугацаат хөрвөх чадварын үзүүлэлт (short-term liquidity ratio), хөрвөх чадварын хүрэлцээний харьцаа (LCR), цэвэр тогтвортой санхүүжилтийн харьцаа (NSFR) зэрэг үзүүлэлтүүдийг тогтмол хянаж, банкны хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээнд удирдаж ажиллахын зэрэгцээ Монголбанкнаас тогтоосон төлбөр түргэн гүйцэтгэх чадварын харьцаа үзүүлэлтийг бүрэн хангаж ажиллаа. Зээлийн багцын чанар, төвлөрлийн эрсдэлийг ТУЗ-с баталсан хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хязгаарын хүрээнд удирдаж ажиллахаас гадна ICAAP аргачлалын хүрээнд төвлөрлийн эрсдэл, болон хүүгийн эрсдэлд шаардагдах өөрийн хөрөнгийн шаардлагыг жил бүр тодорхойлж ICAAP тайланд тусгадаг. Түүнчлэн гэнэтийн хүндрэлт нөхцөл байдал үүсэхэд Банкны санхүүгийн байдал, өөрийн хөрөнгийн хүрэлцээ, хөрвөх чадварт үүсч болох нөлөөллийг тодорхойлох зорилгоор стресс тестийн шинжилгээг тогтмол хийж гүйцэтгэн, түүний үр дүнг гүйцэтгэх удирдлага болон ТУЗ-н түвшинд хэлэлцүүлж, удирдлагын шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлж ажиллаа.																																												
7.	Хувьцаа эзэмшигчдийн өмчлөлийн мэдээлэл /5 ба түүнээс дээш хувьцаа эзэмшигчдийн нэрс эзэмшлийн хувь, нийт хувьцаа эзэмшигчдийн тоо/																																												
	ХасБанк 2023 оны 06 дугаар сард нийт зарласан энгийн хувьцааны 5.01 хувь буюу 52,700,000 ширхэг энгийн хувьцааг олон нийтэд санал болгох замаар хөрөнгө татан төвлөрүүлж, хувь нийлүүлсэн хөрөнгийн хэмжээг 105,270,000,000 төгрөг болгосон. Монголбанк, Монголын хөрөнгийн бирж болон Санхүүгийн зохицуулах хорооноос тус тус олгосон зөвшөөрлийн дагуу, ХасБанкны толгой компани ТэнГэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанканд нэгтгэж, 2025 оны 08 дугаар сарын 11-ний өдөр нэгтгэх ажиллагаа бүрэн дуусгавар болсон. ХасБанкны хувьцаа эзэмшигчдийн бүтэц 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар: <table><tr><th>#</th><th>Хувьцаа эзэмшигчид</th><th>Хувьцааны тоо</th><th>Хувь</th></tr><tr><td>1</td><td>МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди</td><td>203,864,933</td><td>19.37%</td></tr><tr><td>2</td><td>Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/</td><td>175,028,025</td><td>16.63%</td></tr><tr><td>3</td><td>ОРИКС Корпораци</td><td>171,366,429</td><td>16.28%</td></tr><tr><td>4</td><td>Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/</td><td>131,543,137</td><td>12.50%</td></tr><tr><td>5</td><td>Канадын Үндэсний Банк /NBC/</td><td>107,194,412</td><td>10.18%</td></tr><tr><td>6</td><td>Ронок Партнерз Кей Эф Ти</td><td>103,459,739</td><td>9.83%</td></tr><tr><td>7</td><td>Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди</td><td>67,531,041</td><td>6.42%</td></tr><tr><td>8</td><td>Олон нийт</td><td>90,039,468</td><td>8.55%</td></tr><tr><td>9</td><td>Халаасны хувьцаа</td><td>2,672,816</td><td>0.25%</td></tr><tr><td colspan="2">Нийт</td><td>1,052,700,000</td><td>100.00%</td></tr></table>	#	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь	1	МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди	203,864,933	19.37%	2	Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/	175,028,025	16.63%	3	ОРИКС Корпораци	171,366,429	16.28%	4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	131,543,137	12.50%	5	Канадын Үндэсний Банк /NBC/	107,194,412	10.18%	6	Ронок Партнерз Кей Эф Ти	103,459,739	9.83%	7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	67,531,041	6.42%	8	Олон нийт	90,039,468	8.55%	9	Халаасны хувьцаа	2,672,816	0.25%	Нийт		1,052,700,000	100.00%
#	Хувьцаа эзэмшигчид	Хувьцааны тоо	Хувь																																										
1	МАК Инвест Эс Жи Пи Ти Эл Ти Ди	203,864,933	19.37%																																										
2	Олон Улсын Санхүүгийн Корпорац /ОУСК/	175,028,025	16.63%																																										
3	ОРИКС Корпораци	171,366,429	16.28%																																										
4	Европын Сэргээн Босголт Хөгжлийн Банк /ЕСБХБ/	131,543,137	12.50%																																										
5	Канадын Үндэсний Банк /NBC/	107,194,412	10.18%																																										
6	Ронок Партнерз Кей Эф Ти	103,459,739	9.83%																																										
7	Монголия Файненшл Сервисиз Пи Ти И Эл Ти Ди	67,531,041	6.42%																																										
8	Олон нийт	90,039,468	8.55%																																										
9	Халаасны хувьцаа	2,672,816	0.25%																																										
Нийт		1,052,700,000	100.00%																																										
8.	Үнэт цаас гаргагч нь төсөл хэрэгжүүлэх зорилгоор нийтэд санал болгон хувьцаа гаргасан бол төсөл хэрэгжиж эхэлснээс хойш дуусах хүртэл хугацаанд төслийн хэрэгжилтийн явц болон татан төвлөрүүлсэн хөрөнгийн зарцуулалтын тайлан мэдээлэл																																												
	Тайлант хугацаанд олон нийтэд санал болгон хувьцаа гаргах замаар эх үүсвэр татан төвлөрүүлээгүй.																																												

9.	Ногдол ашгийн мэдээлэл	
	2025 оны 04 дүгээр сарын 29-ний өдрийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын шийдвэрийн дагуу 2024 оны жилийн эцсийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 27.00 төгрөг буюу нийт 28.4 тэрбум төгрөгийг хувьцаа эзэмшигчдэдээ ногдол ашиг хэлбэрээр тараасан. Мөн 2025 оны 09 дүгээр сарын 18-ны өдрөөс 10 дугаар сарын 10-ны өдрийн хооронд эчнээ санал хураалтын хэлбэрээр зохион байгуулагдсан хувьцаа эзэмшигчдийн ээлжит бус хурлын шийдвэрийн дагуу 2025 оны I хагас жилийн цэвэр ашгаас нэгж хувьцаанд 18.00 төгрөг буюу нийт 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тараасан байна. 2025 оны II хагас жилийн ногдол ашгийн хувьд 2026 оны 04 дүгээр сарын 29-ний хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар цэвэр ашгаас нэгж хувьцаанд 30.00 төгрөг хуваарилахаар шийдвэрлэж, нийт 31.5 тэрбум төгрөгийн ногдол ашгийг хувьцаа эзэмшигчдэд тараах төлөвлөгөөтэй байна.	
10.	Үнэт цаас гаргагчаас тайланд хугацаанд нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлын тайлангийн мэдээлэл	
	Нийгмийн хариуцлагын чиглэлээр хийгдсэн ажлууд: - Монголын Үндэсний Олимпын Хороо /MYOX/-ны 2025-2026 оны “АЛТАН ТҮНШ” байгууллагаар хамтран ажиллаж байна. - Нийгмийн хариуцлагын хүрээнд спортын үйл ажиллагааг дэмжих зорилгоор Монголын үндэсний олимпын хороо, Монголын талбайн теннисний холбоонд бүртгэлтэй “Grand Tigre” теннисний клубээс зохион байгуулсан “LEXUS CUP 2025”, “LACOSTE CUP 2025” тэмцээнүүдийг ивээн тэтгэж, хамтран ажиллалаа. - Орхон бадминтоны холбооноос Эрдэнэт хотноо зохион байгуулсан “Erdenet open-2025” багийн аварга шалгаруулах тэмцээнд санхүүгийн дэмжлэг олгон хамтран ажиллалаа. - Ажилтнуудынхаа ажил амьдралын тэнцвэрт байдлыг хангаж, илүү чөлөөтэй, урам зоригтой ажиллах боломжийг бүрдүүлэх зорилгоор хэрэгжүүлж буй ажлын 7 цаг хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэхээр боллоо. - ХасLab төслийн хүрээнд Монгол улсын 18 аймаг, 6 сумын нийт 23 ерөнхий боловсролын сургууль болон мэргэжлийн сургалт үйлдвэрлэлийн төвд компьютерын иж бүрэн лаборатори танхим байгуулж, тохижуулан хүлээлгэн өглөө. - Хасын хүлэгүүд мэргэжлийн сагсан бөмбөгийн багтай 2004 оноос хойш 21 дахь жилдээ хамтран ажиллаж, ивээн тэтгэж байна. - Монголын Актив Удирдлагын Корпорацтай хамтран Олон улсын актив удирдлагын компаниудын форум (IPAF)-ыг Монгол Улсад зохион байгуулахад дэмжин ажиллалаа. - Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнд дэмжлэг үзүүлэн ажиллаж байна. - Улсын Нэгдүгээр төв эмнэлгийн 100 жилийн ойг тохиолдуулан дэмжлэг үзүүлэв.	
Мэдээлэл гаргагч этгээд болон мэдээллийн үнэн зөвийг баталсан этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Г.Цэвэгжав Албан тушаал: Гүйцэтгэх захирал Гарын үсэг:  УХН-937 2578697 (Тамга/тэмдэг)		
Мэдээлэл бэлтгэж, хүргүүлсэн этгээдийн гарын үсэг, огноо:		
Овог, нэр: Г.Тамир Албан тушаал: Санхүү хариуцсан захирал		Овог, нэр: Н.Мөнхцэлмэг Албан тушаал: Хууль хариуцсан захирал бөгөөд ТУЗ-ийн нарийн бичгийн дарга
Гарын үсэг:		Гарын үсэг:

ХАСБАНК ХК
(Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж)

Аудитлагдсан Санхүүгийн Тайлан
2025 оны 12 дугаар сарын 31

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлан 2025 оны 12-р сарын 31-ээр тасалбар болгосон

Агуулга	Хуудас
Банкны талаарх мэдээлэл	2
Гүйцэтгэх удирдлагын мэдэгдэл	3
Хараат бус аудиторын дүгнэлт	4 – 8
Товчилсон үгсийн жагсаалт	9
Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан	10
Санхүүгийн байдлын тайлан	11
Өмчийн өөрчлөлтийн тайлан	12
Мөнгөн гүйлгээний тайлан	13 – 14
Санхүүгийн тайлангийн тодруулгууд	15 – 91

ХАСБАНК ХК

Банкны талаарх мэдээлэл

АЛБАН ХАЯГ:	ХасБанкны Байр Ерөнхий Сайд Амарын гудамж, Сүхбаатар дүүрэг, 8-р хороо Шуудангийн Салбар # 46, Шуудангийн Хайрцаг 721, Улаанбаатар 14200 Монгол Улс
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛ:	Санжай Гупта Гүмэнжавын Цэвэгжав Нямтайширын Цэлмүүн Анджей Витак Майкл Мадден Баянсаны Уламбаяр Нираж Ведва Сюзанна Херринг Карр Эмми Чой Стюарт Доналд Холл Доминик Жак Албертус Браггинк (2025 оны 10-р сарын 1-р огцорсон)
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА:	Нямсүрэнгийн Мөнхцэлмэг
АУДИТОР:	Эрнст энд Янг Монголия Аудит ХХК Мэргэшсэн нягтлан бодогчид

ХАСБАНК ХК

ГҮЙЦЭТГЭХ УДИРДЛАГЫН МЭДЭГДЭЛ

ХасБанк ХК-ийн (цаашид “Банк” гэх) Гүйцэтгэх захирал Гүмэнжавын Цэвэгжав болон Санхүү хариуцсан захирал Ганхуягийн Тамир, бид энэхүү тайлангийн 9-өөс 91 дүгээр хуудсанд толилуулсан тайлангуудыг Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөлөөс баталж гаргасан холбогдох СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэсэн бөгөөд 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал, уг өдрөөр тасалбар болгосон тайлант жилийн үйл ажиллагааны үр дүн болон мөнгөн гүйлгээг үнэн зөв, бодитой илэрхийлсэн гэдгийг үүгээр мэдэгдэж байна.



ГҮМЭНЖАВЫН ЦЭВЭГЖАВ
(Гүйцэтгэх захирал)

A handwritten signature in black ink.

ГАНХУЯГИЙН ТАМИР
(Санхүү хариуцсан захирал)

Монгол Улс, Улаанбаатар хот
Огноо: 2026 оны 03 дугаар сарын 20



Shape the future
with confidence

Ernst & Young Mongolia Audit LLC
15/F, Altan Joloo Tower
Seoul Street 13/A
Ulaanbaatar 14252
Mongolia

Tel : +976 11 314032 / +976 11 312005
ey.com

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд

Дүгнэлт

Бид ХасБанк ХК (“Банк”)-ийн 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх Банкны санхүүгийн байдлын тайлан, тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн ашиг алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлан, нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын товчоо болон бусад тайлбар тодруулгуудаас бүрдсэн санхүүгийн тайлангуудад аудит хийж гүйцэтгэлээ.

Бидний дүгнэлтээр дээр нэрлэсэн санхүүгийн тайлангууд нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны санхүүгийн байдал хийгээд тухайн өдрөөр дуусгавар болсон санхүүгийн жилийн үйл ажиллагааны үр дүн, мөнгөн гүйлгээг Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (“НББОУСЗ”)-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу материаллаг алдаагүй, бодитойгоор илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Бид энэхүү аудитын ажлыг Аудитын олон улсын стандартууд (“АОУС”)-ын дагуу хийж гүйцэтгэлээ. Уг стандартуудын дагуу хүлээсэн бидний үүрэг хариуцлагыг энэхүү тайлангийн “*Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага*” хэсэгт харуулав. Бид Нягтлан Бодогчдын ёс зүйн олон улсын стандартын зөвлөлөөс баталсан “*Мэргэшсэн нягтлан бодогчдын ёс зүйн дүрэм*”-ийн дагуу Банкнаас хараат бус бөгөөд уг дүрэмд заасны дагуу өөрсдийн бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан дүгнэлтэд хангалттай, зохистой үндэслэл болж чадна гэдэгт бид итгэлтэй байна.

Аудитын гол асуудлууд

Аудитын гол асуудлууд гэдэг нь тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их ач холбогдолтой байсан гэж аудиторын мэргэжлийн үнэлэмжээр үзсэн асуудлууд юм. Эдгээр асуудлуудыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь анхаарч, аудиторын дүгнэлт өгөхдөө авч үзсэн бөгөөд бид уг асуудлуудын талаар тусдаа дүгнэлт гаргадаггүй болно. Аудитын гол асуудлыг бид хэрхэн авч үзсэн талаарх тайлбарыг дор өгөв.

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага хэсэгт дурдсан үүрэг хариуцлагууд болон эдгээр асуудлуудтай холбоотой үүрэг хариуцлагыг бид бүрэн биелүүлсэн. Үүний дагуу бид санхүүгийн тайлангуудын материаллаг буруу илэрхийлэгдэх эрсдэлийн үнэлгээнд тохирсон аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Дор дурдсан асуудлыг анхаарч үзэхдээ гүйцэтгэсэн горимуудыг багтаасан аудитын горимуудын үр дүн нь энд хавсаргасан санхүүгийн тайлангуудад өгсөн бидний аудитын дүгнэлтийн үндэслэл болно.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Зээлийн үнэ цэнийн бууралт Удирдлага нь хорогдуулсан өртгөөр бүртгэгдсэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцохдоо үнэлэмж болон өндөр түвшний төсөөлөл ашигладаг. Хорогдуулсан өртгөөр бүртгэсэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаа нь 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх Банкны нийт хөрөнгийн 59 орчим хувийг эзэлж байгаа бөгөөд холбогдох тооцооллын тодорхойгүй байдлаас үүдэн харилцагчдад олгосон зээл болон урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг бид аудитын гол асуудал гэж үзсэн. Үнэ цэнийн бууралтын аргачлал нь ирээдүйг таамагласан Хүлээгдэж Буй Зээлийн Алдагдал ("ХБЗА")-ын загварт суурилсан. Энэхүү ХБЗА-ын загварын бүрэлдэхүүн хэсгүүд нь ихээхэн төсөөлөл, болон тооцоолол шаарддаг. Үүнд: - Санхүүгийн хөрөнгийн шатлал; - ХБЗА-ын загвар боловсруулах, загварын гол өгөгдлүүд болох Төлбөр төлөгдөхгүй байх магадлал ("ТТБМ") болон Алдагдал үүсэх магадлал ("АҮМ")-ийг сонгох; - Чанаргүйдэлд Өртөх Дүн ("ЧӨД") болон ашиглагдаагүй зээлийн үүргийн хөрвүүлэлтийн коэффициентийг тодорхойлох; - ХБЗА-ын загварт оруулах эдийн засгийн өгөгдлүүдийг тодорхойлохын тулд ирээдүйн макро эдийн засгийн хувилбаруудыг сонгох, мөн тэдгээрийг магадлалаар нь жинлэх; болон - Ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгалыг тооцоход хэрэглэсэн олон төрлийн төсөөлөл болон хүчин зүйлс дээр суурилан тусгайлан үнэлсэн зээлүүдийн үнэ цэнийн бууралтын санг тооцоолох. Холбогдох нягтлан бодох бүртгэлийн бодлого болон нягтлан бодох бүртгэлийн гол дүгнэлт, тооцооллууд болон таамаглалыг санхүүгийн тайлангийн Тодруулга 2.4 болон 2.2-д тус тус толилуулсан. Харилцагчдад олгосон зээл болон урьдчилгаатай хамааралтай бусад толилуулга болон зээлийн эрсдэлийн удирдлагыг санхүүгийн тайлангийн Тодруулга 9, 16 болон 31.2-д тус тус толилуулсан.	2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтын алдагдлын санг тооцоолох аргачлалыг үнэлэхдээ бид Банкны ХБЗА-ыг батлах, бүртгэх, хянах хяналтын загвар болон үйл ажиллагааны үр дүнтэй байдлыг үнэлэх, мөн харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралтыг тооцоолох ХБЗА-ын загварт банкны ашигласан арга зүй, өгөгдөл, төсөөллүүдийг үнэлэх зэрэг аудитын горимуудыг гүйцэтгэсэн. Арга зүйг үнэлэхдээ бид банкны ХБЗА-ын загвар болон ашигласан арга зүй, таамаглалын удирдлагын үндэслэлийн талаарх ойлголтыг авч, загварын үндэслэлтэй байдлыг үнэлж, салбарын жишигтэй харьцуулсан. Түүнчлэн бид ашигласан таамаглалуудын үндэслэлтэй байдал, шатлалын ангиллын үндэслэл, ТТБМ, АҮМ болон ЧӨД-г тодорхойлох оновчтой байдал, загварт тусгагдсан макро эдийн засгийн хэтийн хувьсагчдыг авч үзсэн. Шатлалын ангилал зохистой эсэхийг шалгахдаа бид зээлийн хугацаа хэтрэлтийн мэдээлэл, харилцагчдад оноосон зээлжих зэрэглэлийг анхны хүлээн зөвшөөрсөн өдрөөр болон санхүүгийн тайлангийн өдрөөр тус тус шалгасан. Бид мөн насжилтын тайлангийн дүнг санхүүгийн бүртгэлд тусгасан дүнтэй тулгах замаар насжилтын тайлангийн иж бүрэн байдлыг шалгаж, санамсаргүй түүврийн аргаар насжилтын тайлангийн мэдээллүүдийг холбогдох баримтуудтай тулгах замаар насжилтын тайлангийн үнэн зөв байдлыг шалгасан. Бид ХБЗА-ын загварт ашигласан гол өгөгдлүүдийг Банкны боломжит дотоод эх үүсвэрээс олж авсан түүхэн мэдээлэл, гадаад эх үүсвэрээс олж авсан тухайн салбарын болон санхүү, эдийн засгийн мэдээллүүдтэй харьцуулсан. Бидний хяналтын горимд дараах ажлууд багтсан. Үүнд: - Түүхэн ТТБМ, АҮМ-ийг тодорхойлох тооцоололд ашигласан дотоод болон гадаад эх сурвалжийн мэдээллүүдийн зөв зохистой байдлыг санамсаргүй түүврийн аргаар шалгасан; - Макро эдийн засгийн хэмжүүрүүдийг боломжит гадаад эх сурвалжийн мэдээллүүдтэй тулгасан; - ЧӨД болон зээлийн хөрвүүлэлтийн коэффициентүүдийн хүлээлтийн үнэн зөв байдлыг шалгасан;



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Аудитын гол асуудлууд (үргэлжлэл)

Аудитын гол асуудал	Гүйцэтгэсэн аудитын горимууд
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгааны үнэ цэнийн бууралт	
	Үнэ цэнийн бууралтыг үнэлэх тусгайлан үнэлсэн зээлүүдээс сонгогдсон түүврүүдийн хувьд бид ирээдүйд хүлээгдэж буй мөнгөн урсгал болон барьцаа хөрөнгийн бодит үнэ цэнийн талаарх Банкны таамаглалуудыг хянаж үзсэн. Бид ХБЗА-ын загварын гол өгөгдлүүдэд ашигласан үнэлэмжийн тууштай байдлыг авч үзсэн. Мөн бид санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгуудын зохистой байдлыг үнэлсэн.

Жилийн тайланд тусгагдсан бусад мэдээлэл

Бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан болон манай аудиторын тайлангаас бусад Жилийн тайланд багтсан мэдээллээс бүрдэнэ. Бусад мэдээлэлд удирдлага хариуцлага хүлээнэ. Банкны жилийн тайлан энэхүү аудиторын тайлан гарсан өдрөөс хойш гарахаар хүлээгдэж байна.

Санхүүгийн тайлангуудад өгсөн бидний дүгнэлт нь бусад мэдээлэлд хамаарахгүй бөгөөд тэдгээрт аливаа хэлбэрийн баталгаажуулах дүгнэлт гаргаагүй болно.

Санхүүгийн тайлангуудын аудиттай холбоотой бидний хүлээх хариуцлага нь бусад мэдээллийг уншиж, тэдгээр нь санхүүгийн тайлангууд эсвэл аудитын явцад бидний олж авсан мэдээллээс материаллаг байдлаар зөрүүтэй эсвэл алдаатай эсэхийг харгалзаж үзэх явдал юм.

Санхүүгийн тайлангуудтай холбоотойгоор удирдлага болон засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийн хүлээх хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартын дагуу бэлтгэх, бодитойгоор илэрхийлэх ба залилан, алдааны улмаас үүсч болох материаллаг буруу илэрхийлэлгүй санхүүгийн тайлангуудыг бэлтгэх боломжийг бий болгоход шаардлагатай гэж удирдлагын тодорхойлсон дотоод хяналтуудад удирдлага хариуцлага хүлээнэ.

Банкны удирдлага нь санхүүгийн тайлангуудыг бэлтгэхдээ Банкны үйл ажиллагааг зогсоох эсхүл татан буулгахаар төлөвлөсөн эсхүл эдгээрээс өөр бодит сонголт байхгүйгээс бусад тохиолдолд санхүүгийн тайлангуудыг тасралтгүй байх зарчмын дагуу Банкны үйл ажиллагааг тасралтгүй явуулах чадварыг үнэлэх, боломжтой бол тасралтгүй байх зарчимтай холбоотой асуудлуудыг тодруулах, нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх суурийг хэрэглэх үүрэгтэй. Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүд нь Банкны санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэгтэй.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Санхүүгийн тайлангийн аудитад хүлээх аудиторын үүрэг хариуцлага

Залилан эсхүл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаа олж авах, дүгнэлт бүхий аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм.

Зохистой баталгаажуулалт гэдэг нь өндөр түвшний баталгаажуулалт боловч “АОУС”-ын дагуу хийгдсэн аудит нь оршин байгаа материаллаг буруу илэрхийллүүдийг байнга илрүүлнэ гэсэн баталгаа биш юм. Буруу илэрхийллүүд нь залилан эсхүл алдаанаас үүсч болох ба хэрэв тэдгээр нь дангаараа эсхүл нийтдээ санхүүгийн тайланд үндэслэн гаргасан хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогдоно.

“АОУС”-ын дагуу хийх аудитын үед бид мэргэжлийн үнэлэмж, мэргэжлийн үл итгэх зарчмыг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Залилан эсхүл алдааны улмаас үүсч болох санхүүгийн тайлангийн материаллаг буруу илэрхийллийн эрсдэлүүдийг таних, үнэлэх, тэдгээр эрсдэлд тохирох аудитын горимуудыг боловсруулах, гүйцэтгэх, өөрсдийн дүгнэлтэд үндэслэл болохуйц хангалттай, зохистой аудитын нотолгоог олж авах. Залилан нь хуйвалдах, бичиг баримт хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу мэдэгдэл хийх, дотоод хяналтыг зөрчих зэрэг үйлдлүүдтэй холбоотой байж болох тул залилангаас үүдэн гарсан материаллаг буруу илэрхийллийг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүдэн гарсан буруу илэрхийллийг ирүүлэхгүй байх эрсдэлээс өндөр байдаг.
- Банкны дотоод хяналтын үр нөлөөтэй байдалд дүгнэлт өгөх зорилгоор биш тухайн нөхцөл байдалд тохирохуйц аудитын горим боловсруулахын тулд аудитад хамааралтай дотоод хяналтын талаар ойлголт олж авах.
- Хэрэглэсэн нягтлан бодох бүртгэлийн бодлогууд нь зохистой эсэх, удирдлагын зүгээс нягтлан бодох бүртгэлийн ойлголцоолсон тооцооллууд, тэдгээрт холбогдох тодруулгууд нь үндэслэлтэй эсэхийг үнэлэх.
- Нягтлан бодох бүртгэлийн тасралтгүй байх зарчмыг удирдлага зохистой хэрэглэсэн эсэх, олж авсан аудитын нотолгоонд үндэслэн Банкны үйл ажиллагаагаа тасралтгүй явуулах чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ үүсгэж болох үйл явдал эсхүл нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг дүгнэх. Хэрэв материаллаг тодорхой бус байдал байна гэж дүгнэвэл, бид аудиторын тайландаа санхүүгийн тайлангийн холбогдох тодруулгыг хийж өгөх эсхүл ийм тодруулга хангалтгүй бол дүгнэлтээ өөрчлөх шаардлагатай болдог. Аудиторын тайлан гарах өдөр хүртэл олж авсан аудитын нотолгоонд үндэслэн бид дүгнэлтээ гаргадаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсхүл нөхцөл байдал Банкны тасралтгүй байх зарчмыг алдагдуулж болно.
- Санхүүгийн тайлангууд (үүнд тодруулгууд багтана)-ын ерөнхий толилуулга, бүтэц, агуулгыг үнэлэх мөн санхүүгийн тайлангууд нь бодитой илэрхийлэгдэх шаардлагыг хангахуйц байдлаар холбогдох ажил гүйлгээ, үйл явдлуудыг илэрхийлсэн эсэхийг үнэлэх.

Бид аудитын ажлын төлөвлөсөн хамрах хүрээ, цаг хугацаа, томоохон хэмжээний дутагдал болон аудитын явцад олж тогтоосон дотоод хяналтын томоохон доголдол зэргийг багтаасан асуудлуудыг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгддэг.

Мөн бид өөрсдийн хараат бус байдлыг хөндсөн ёс зүйн шаардлагуудыг хангасан тухай мэдэгдлийг засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд хүргэж, бидний хараат бус байдалд зохистойгоор хамааралтай гэж үзэж болох бүхий л харилцаа болон бусад асуудлуудын талаар болон хэрвээ шаардлагатай тохиолдолд аливаа эрсдэлийг арилгахаар авсан арга хэмжээг мэдэгддэг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдэд мэдэгдсэн асуудлаас бид тухайн тайлант жилийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн өндөр ач холбогдол бүхий асуудлуудыг аудитын онцгойлсон асуудлууд гэж тодорхойлдог. Хууль тогтоомж нь уг асуудлуудын талаар олон нийтэд мэдээллэхийг хориглосон эсхүл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлуудын талаар мэдээллэх нь олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлуудыг бид аудиторын тайландаа толилуулдаг.

Энэхүү хараат бус аудиторын тайланг гаргаж буй аудитын гэрээт ажлын партнер нь Адриан Чу болно.



Shape the future
with confidence

ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (ҮРГЭЛЖЛЭЛ)

ХасБанк ХК-ийн хувьцаа эзэмшигчдэд (Үргэлжлэл)

Бусад зүйл

Энэхүү тайланг өөр ямар нэгэн зорилгоор биш, Монгол Улсын "Компанийн тухай хууль"-ийн 94 дүгээр зүйлд заасны дагуу Банкны хувьцаа эзэмшигчдийн захиалгаар аудитыг гүйцэтгэн Банкны хувьцаа эзэмшигчдэд зориулан гаргалаа. Бид энэхүү тайлангийн агуулгын хүрээнд өөр аливаа нэг гуравдагч талын өмнө хариуцлага хүлээхгүй болно.



Ernst & Young Mongolia Audit LLC

ЭРНСТ ЭНД ЯНГ МОНГОЛИЯ АУДИТ ХХК

Мэргэшсэн нягтлан бодогчид

УЛААНБААТАР ХОТ

Гарын үсэг зурж баталсан

Адриан Чу
Партнер

Улаанбаатар хот, Монгол Улс
Огноо: 2026 оны 03 дугаар сарын 20

Товчилсон үгсийн жагсаалт

ХӨ	Хорогдуулсан өртөг
ХББ	Хөрөнгөөр баталгаажсан бонд
МБ	Монголбанк
ХБЗА	Хүлээгдэж Буй Зээлийн Алдагдал
ҮАХТ	Үр Ашигт Хүүгийн Түвшин
БЗЭБХ	Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө
БҮЦБДО	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлого
БҮЦАА	Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг, алдагдал
ЗГ	Монгол улсын засгийн газар
ДНБ	Дотоодын Нийт Бүтээгдэхүүн
СТОУС	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандартууд
СТОУС 7	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 7: Санхүүгийн хэрэгслүүдийн тодруулга
СТОУС 9	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 9: Санхүүгийн хэрэгслүүд
СТОУС 13	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт 13: Бодит үнэ цэнийн хэмжилт
НББОУСЗ	Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл
СТОУТХ	Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Тайлбарын Хороо
АҮМ	Алдагдал үүсэх магадлал
SOFR	Америкийн нэгдсэн улсын банк хоорондын овернайт санхүүжилтийн хүү
БДО	Бусад дэлгэрэнгүй орлого
ТТБМ	Төлбөр төлөгдөхгүй байх магадлал
ИЗББ	Ипотекийн зээлээр баталгаажсан бонд
ҮЦСК	Үнэт цаасны санхүүжилтийн корпораци ХХК
ЗҮТБХТ	Зөвхөн үндсэн төлбөр болон хүүгийн төлбөр
ХИЭ	Хамгийн Их Эрсдэл
МИК	Монголын Ипотекийн Корпораци
ЖДҮ	Жижиг, Дунд Үйлдвэрлэл
НӨАТ	Нэмэгдсэн Өртгийн Албан Татвар

ХАСБАНК ХК

Ашиг, алдагдал ба бусад дэлгэрэнгүй орлогын тайлан
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болгосон жилийн

	Тод- руулга	2025 мян.төг	2024 мян.төг
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүү болон түүнтэй адилтгах орлого	4.1	841,642,694	703,265,483
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүү болон түүнтэй адилтгах орлого	4.2	12,754,214	12,974,358
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4.3	(536,698,331)	(396,254,799)
Хүүгийн цэвэр орлого	4	317,698,577	319,985,042
Хураамж ба шимтгэлийн орлого	5	48,706,882	44,072,758
Хураамж ба шимтгэлийн зардал	5	(18,766,059)	(15,935,071)
Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого	5	29,940,823	28,137,687
Арилжааны цэвэр ашиг	6	16,491,643	15,983,088
БҮЦАА-д бүртгэсэн бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого	7	7,345,204	7,639,026
Үйл ажиллагааны бусад цэвэр орлого	8	22,646,970	10,962,475
Үйл ажиллагааны нийт орлого		394,123,217	382,707,318
Үнэ цэнийн бууралтын цэвэр (зардал)/буцаалт	9	(12,731,677)	2,129,641
Үйл ажиллагааны цэвэр орлого		381,391,540	384,836,959
Үйл ажиллагааны зардал	10	(159,399,655)	(154,856,979)
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	22	1,394,524	484,712
Татварын өмнөх ашиг		223,386,409	230,464,692
Орлогын татварын зардал	11.1	(50,790,225)	(58,784,404)
Тайлант жилийн ашиг		172,596,184	171,680,288
Бусад дэлгэрэнгүй орлого (татварын дараах):			
<i>Дараагийн тайлант хугацаанд ашиг, алдагдлын тайлан руу дахин ангилагдахгүй бусад дэлгэрэнгүй орлого:</i>			
Хөрөнгө оруулалтын бодит үнэ цэнийн нөөцийн өөрчлөлт, татварын дараах		175,798	(856,106)
Бусад дэлгэрэнгүй орлого, татварын дараах		175,798	(856,106)
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй орлого		172,771,982	170,824,182
Нэгж хувьцаанд ногдох ашиг (төгрөгөөр):			
Нэгж хувьцаанд ногдох үндсэн ашиг	12	164.12	163.10
Нэгж хувьцаанд ногдох хорогдуулсан ашиг	12	164.12	163.10

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХАСБАНК ХК

Санхүүгийн байдлын тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх

	Тод- руулга	2025 мян.төг	2024 мян.төг
ХӨРӨНГӨ			
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	13.1	238,239,937	33,914,061
Монголбанк дахь заавал байлгах нөөц	13.2	504,508,164	397,890,873
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	14.2	46,166,061	10,050,723
Санхүүгийн хэрэгслүүд	14.1	147,862,972	112,300,780
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	14.1	165,355,679	209,855,668
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө			
Өмчийн хэрэгслүүд	15	3,728,279	3,910,731
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө			
Банк ба санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	16.1	443,313,886	776,096,768
Өрийн хэрэгслүүд	16.2	1,103,217,365	1,133,892,280
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	16.3	4,016,649,082	3,472,735,003
Бусад хөрөнгө	17	76,677,824	61,573,787
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө	18	1,586,191	1,089,949
Үндсэн хөрөнгө ба ашиглах эрхтэй хөрөнгө	19	88,161,716	79,706,337
Биет бус хөрөнгө	20	14,741,075	16,833,961
Хойшлогдсон татварын хөрөнгө	11.2	11,684,447	11,942,798
НИЙТ ХӨРӨНГӨ		6,861,892,678	6,321,793,719
ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ			
ӨР ТӨЛБӨР			
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд			
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	14.2	6,812,173	9,542,837
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр			
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж	21.1	3,074,022	276,333,956
Харилцагчдын харилцах, хадгаламж	21.2	3,749,383,957	3,424,786,562
Зээлээр авсан санхүүжилт	21.3	2,096,275,640	1,727,756,398
Хойшлогдсон нөхцөлт хандив	22	3,636,480	12,397,895
Түрээсийн өр төлбөр	23	11,380,292	7,233,884
Бусад өр төлбөр	24	125,146,763	105,974,775
Орлогын албан татварын өглөг	11.1	11,253,643	26,164,657
НИЙТ ӨР ТӨЛБӨР		6,006,962,970	5,590,190,964
ЭЗДИЙН ӨМЧ			
Энгийн хувьцаа	25	105,270,000	105,270,000
Халаасны хувьцаа	25	(267,282)	(29,668)
Нэмж төлөгдсөн капитал	25	28,513,791	30,388,871
Нөөцүүд	26	78,806,191	80,566,643
Хуримтлагдсан ашиг		642,607,008	515,406,909
НИЙТ ЭЗДИЙН ӨМЧ		854,929,708	731,602,755
НИЙТ ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		6,861,892,678	6,321,793,719

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХАСБАНК ХК

Өмчийн өөрчлөлтийн тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Энгийн хувьцаа мян.төг (Тодруулга 25)	Халаасны хувьцаа мян.төг Тодруулга 25)	Нэмж төлөгдсөн капитал мян.төг (Тодруулга 25)	Нөөцүүд* мян.төг (Тодруулга 26)	Хуримтлагдсан ашиг мян.төг	Нийт эздийн өмч мян.төг
2025 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар	105,270,000	(29,668)	30,388,871	80,566,643	515,406,909	731,602,755
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	172,596,184	172,596,184
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	175,798	-	175,798
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	175,798	172,596,184	172,771,982
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	(482,498)	482,498	-
Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг**	-	-	-	-	(47,332,335)	(47,332,335)
Худалдан авсан халаасны хувьцаа	-	(237,614)	(1,875,080)	-	-	(2,112,694)
Тусгай зориулалттай нөөцөд/(нөөцөөс) шилжүүлсэн	-	-	-	(1,453,752)	1,453,752	-
2025 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар	105,270,000	(267,282)	28,513,791	78,806,191	642,607,008	854,929,708
2024 оны 1 сарын 1-ний өдрийн байдлаар	105,270,000	-	30,586,768	86,418,906	399,787,064	622,062,738
Тайлант жилийн ашиг	-	-	-	-	171,680,288	171,680,288
Бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	(856,106)	-	(856,106)
Нийт дэлгэрэнгүй орлого	-	-	-	(856,106)	171,680,288	170,824,182
Хэрэгжсэн дахин үнэлгээний нөөц	-	-	-	(176,244)	176,244	-
Бэлэн мөнгөөр олгосон ногдол ашиг***	-	-	-	-	(61,056,600)	(61,056,600)
Худалдан авсан халаасны хувьцаа	-	(29,668)	(197,897)	-	-	(227,565)
Тусгай зориулалттай нөөцөд/(нөөцөөс) шилжүүлсэн	-	-	-	(4,819,913)	4,819,913	-
2024 оны 12 сарын 31-ний өдрийн байдлаар	105,270,000	(29,668)	30,388,871	80,566,643	515,406,909	731,602,755

*Нөөцүүдэд тусгай зориулалтын нөөц багтсан ба уг нөөцийг Монголбанкны шаардлагад нийцүүлэн байгуулсан бөгөөд Монголбанкны зөвшөөрлөөр Банкны хувьцаа эзэмшигчдэд хуваарилах боломжтой (Тодруулга 26).

** Банкны хувьцаа эзэмшигчдэд 2025 оны 2-р сарын 18 болон 2025 оны 8-р сарын 21-ний өдөр, 28.4 тэрбум төгрөг болон 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг хуваарилахыг Монголбанк зөвшөөрч, Банк 2025 оны 4-р сарын 29 болон 2025 оны 10-р сарын 10-нд ногдол ашиг олгосон.

*** Банкны хувьцаа эзэмшигчдэд 2024 оны 2-р сарын 2, 2024 оны 4-р сарын 29 болон 2024 оны 9-р сарын 4-ний өдөр, 15.5 тэрбум төгрөг, 26.6 тэрбум төгрөг болон 18.9 тэрбум төгрөгийн ногдол ашиг хуваарилахаар шийдвэрлэсэн. Ногдол ашиг хуваарилахыг Монголбанк зөвшөөрч, Банк 2024 оны 2-р сарын 9, 2024 оны 4-р сарын 30 болон 2024 оны 9-р сарын 9-нд ногдол ашиг олгосон.

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

ХАСБАНК ХК

Мөнгөн гүйлгээний тайлан

2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тодруулга	2025 мян.төг	2024 мян.төг
ҮНДСЭН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Татварын өмнөх ашиг		223,386,409	230,464,692
Тохируулга:			
Үндсэн хөрөнгө борлуулсны гарз	8	5,518	4,038
Хураан авсан хөрөнгө борлуулсны (олз)/гарз	8	(1,263,956)	18,973
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны олз	8, 18	(569,895)	(170,818)
Өмчийн хэрэгслүүд борлуулсны олз	8	(436,430)	-
Валютын ханшийн хэрэгжээгүй гарз/(олз)	8	30,293,287	(36,698,742)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт	8	(38,846,001)	41,960,917
Үнэ цэнийн бууралтын цэвэр зардал/(буцаалт)	9	12,731,677	(2,129,641)
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн БҮЦ-ийн өөрчлөлт	6, 7	(367,642)	(1,660,544)
Үндсэн хөрөнгийн элэгдэл	10	10,928,787	8,419,942
Ашиглах эрхтэй хөрөнгийн элэгдэл	10	6,146,024	5,178,941
Биет бус хөрөнгийн хорогдол	10	3,018,506	3,057,438
Үндсэн хөрөнгө данснаас хассаны гарз	10	141,460	84,910
Хураан авсан хөрөнгийн үнэ цэнийн бууралтын (буцаалт)/зардал	8	(1,008,216)	1,037,266
БЗЭБХ-ийн үнэ цэнийн бууралтын (буцаалт)/зардал	8	(59,053)	116,937
Карбон кредит борлуулсны орлого	8	(7,526,222)	-
Хойшлогдсон нөхцөлт хандивын хорогдуулга	22	(1,394,524)	(484,712)
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлого	4.1	(841,642,694)	(703,265,483)
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого	4.2, 6, 7	(24,865,999)	(23,462,323)
Хүү болон түүнтэй адилтгах зардал	4.3	536,698,331	396,254,799
Хорогдуулсан өртгөөрх болон БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгөөс хүлээн авсан хүү		701,592,572	582,475,793
Хорогдуулсан өртгөөрх болон БҮЦАА-д бүртгэх санхүүгийн өр төлбөрт төлсөн хүү		(357,236,917)	(262,971,939)
Үйл ажиллагааны хөрөнгө ба өр төлбөрийн өөрчлөлтийн өмнөх үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		249,725,022	238,230,444
Үйл ажиллагааны хөрөнгийн өөрчлөлтүүд:			
Монголбанк дахь заавал байлгах нөөц		(106,509,723)	(158,355,145)
Урвуу репо хэлцэл		-	99,787,135
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа		(689,487,886)	(973,206,484)
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд		29,695,161	44,840,761
Бусад хөрөнгө		(14,801,711)	(1,280,970)
Үйл ажиллагааны өр төлбөрийн өөрчлөлтүүд:			
Банк ба санхүүгийн байгууллагын байршуулсан харилцах, хадгаламж		(273,117,101)	239,101,048
Репо хэлцэл		-	(149,611,113)
Харилцагчдын харилцах, хадгаламж		296,622,704	545,238,225
Бусад өр төлбөр		8,549,321	(29,976,128)
Үндсэн үйл ажиллагаанд хүлээн зарцуулсан мөнгөн гүйлгээ		(499,324,213)	(145,232,227)
Төлсөн орлогын албан татвар	11.1	(65,501,487)	(65,166,388)
Үндсэн үйл ажиллагаанд зарцуулсан цэвэр мөнгөн гүйлгээ		(564,825,700)	(210,398,615)

ХАСБАНК ХК

Мөнгөн гүйлгээний тайлан (Үргэлжлэл)
2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон жилийн

	Тодруулга	2025 мян.төг	2024 мян.төг
ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Өрийн хэрэгслүүдээс хүлээн авсан хүү		140,012,919	130,107,544
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хөрөнгө оруулалт борлуулсны орлого		4,685,300	1,147,500
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүдийн худалдан авалт		(49,181,600)	(40,000,000)
БҮЦБДО-д бүртгэх өмчийн хэрэгслүүд борлуулсны орлого		853,280	-
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд борлуулсны орлого		35,364,472	3,280,993
Үндсэн хөрөнгө борлуулсны орлого		55,317	7,917
Үндсэн хөрөнгийн худалдан авалт	19	(17,453,233)	(14,426,045)
Биет бус хөрөнгийн худалдан авалт	20	(942,570)	(1,224,285)
Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө борлуулсны орлого	18	1,843,130	2,241,415
Хураан авсан хөрөнгө борлуулсны орлого	17	5,064,497	10,478,712
Хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ		120,301,512	91,613,751
САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ			
Зээлээр авсан санхүүжилтэд төлсөн хүү		(171,627,763)	(115,797,153)
Зээлээр авсан санхүүжилтийн татан авалт		1,110,066,655	737,565,385
Зээлээр авсан санхүүжилтийн эргэн төлөлт		(640,541,289)	(238,665,336)
Худалдан авсан халаасны хувьцаа		(2,112,694)	(227,565)
Төлсөн ногдол ашиг		(47,332,335)	(61,056,600)
Хүлээн авсан хойшлогдсон нөхцөлт хандив	22	-	307,516
Түрээсийн үндсэн өр төлбөрийн төлөлт		(6,434,328)	(5,946,764)
Санхүүгийн үйл ажиллагаанаас хүлээн авсан цэвэр мөнгөн гүйлгээ		242,018,246	316,179,483
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн ханшийн өөрчлөлтийн нөлөө		28,337,776	(1,055,015)
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн цэвэр (бууралт)/өсөлт		(174,168,166)	196,339,604
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		1,896,335,539	1,699,995,935
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13.3	1,722,167,373	1,896,335,539
Санхүүжилтийн үйл ажиллагаанаас үүдэлтэй өр төлбөрүүдийн өөрчлөлт:			
Түрээсийн өр төлбөр		2025 мян.төг	2024 мян.төг
1-р сарын 1-нээр		7,233,884	7,675,609
Нэмэгдсэн мөнгөн бус гүйлгээ		12,116,330	5,865,928
Цуцлагдсан түрээс		(2,140,291)	(1,159,561)
Хүүгийн зардал		604,697	798,672
Төлсөн түрээсийн төлбөр		(6,434,328)	(5,946,764)
12-р сарын 31-нээр	23	11,380,292	7,233,884
Зээлээр авсан санхүүжилт		2025 мян.төг	2024 мян.төг
1-р сарын 1-нээр		1,727,756,398	1,238,768,595
Шинээр нэмэгдсэн		1,110,066,655	737,565,385
Эргэн төлөлт		(640,541,289)	(238,665,336)
Хүүгийн эргэн төлөлт		(171,627,763)	(115,797,153)
Монголбанк болон Засгийн газарт МИК - Давуу эрхтэй ИЗББондоор төлсөн мөнгөн бус хөдөлгөөн		(163,070,700)	(25,434,300)
Ханшийн зөрүү		63,237,649	7,165,901
Хуримтлагдсан хүүгийн зардал		170,454,690	124,153,306
12-р сарын 31-нээр	21.4	2,096,275,640	1,727,756,398

Санхүүгийн тайлангийн тодруулгууд нь энэхүү санхүүгийн тайлангийн салшгүй хэсэг болно.

1. Банкны мэдээлэл

Тус банкны үндсэн үйл ажиллагаа нь Монголбанкнаас олгосон 24 тоот зөвшөөрлийн дагуу банк, санхүүгийн үйлчилгээ байна. Тайлант жилд банкны үйл ажиллагааны мөн чанарт өөрчлөлт гараагүй болно.

Банк нь Монгол улсад бүртгэлтэй, тус улсын нутаг дэвсгэр дээр үйл ажиллагаа явуулдаг, Монголын хөрөнгийн биржид (МХБ) бүртгэлтэй нээлттэй хувьцаат компани юм. Банкны албан хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 1-р хороо, Ерөнхий сайд Амарын гудамж, ХасБанкны байр бөгөөд үйл ажиллагаагаа явуулдаг хаяг нь Монгол улс, Улаанбаатар хот 14252, Сүхбаатар дүүрэг, 3-р хороо, Сөүлийн гудамж 13/А, Алтан Жолоо Тауэр 9 давхар.

Банкны нийт хувьцааг олон нийт эзэмшдэг бөгөөд 0.25% (2024 онд: 0.03%)-ыг олон нийтээс буцаан худалдан авч халаасалсан.

2025 оны 7-р сарын 30-ны өдрөөр Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийн данс бүртгэлийг хааж ХасБанк ХК-д нэгтгэсэн. Тэнгэр Санхүүгийн Нэгдэл ХХК-ийг ХасБанканд нэгтгэх хэлбэрээр өөрчлөн байгуулсныг хуулийн этгээдийн улсын бүртгэлд 2025 оны 8-р сарын 11-ний өдөр бүртгэсэн.

2025 оны 12-р сарын 31-ний өдрийн байдлаар Банкны нөлөө бүхий 5%-иас дээш хувьцаа эзэмшигчид нь:

- ▶ МАК Инвест ЭсЖи ПиТиИ ЭлТиДи
- ▶ Олон Улсын Санхүүгийн Корпораци (ОУСК)
- ▶ ОРИКС Корпораци
- ▶ Европын Сэргээн Босголт, Хөгжлийн Банк (ЕСБХБ)
- ▶ Канадын Үндэсний Банк (КҮБ)
- ▶ Ронок Партнерс Кей Эф Ти
- ▶ Монголиа Файнаншл Сервисез ПиТиИ ЭлТиДи

Санхүүгийн тайланг Төлөөлөн Удирдах Зөвлөлийн 2026 оны 03 дугаар сарын 20-ны өдрийн шийдвэрээр батлан гаргасан.

2. Нягтлан бодох бүртгэлийн бодлого

2.1 Тайлан бэлтгэсэн суурь

Банкны санхүүгийн тайлангууд нь Нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын зөвлөл (НББОУСЗ)-өөс баталж гаргасан СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын дагуу бэлтгэгдсэн болно.

Санхүүгийн тайлангууд нь санхүүгийн үүсмэл хэрэгслүүд, БҮЦБДО бүртгэгдэх өрийн болон өмчийн хэрэгслүүд, БҮЦАА бүртгэгдэх санхүүгийн хэрэгслүүд, газар ба барилгыг эс тооцвол түүхэн өртгийн зарчмаар бэлтгэгдсэн болно. Борлуулах зорилгоор эзэмшиж буй хөрөнгө болон өмчлөх бусад хөрөнгийг дансны үнэ ба борлуулалтын зардлыг хассан бодит үнэ цэнийн аль багаар бүртгэдэг. Санхүүгийн тайлан дахь дүнгүүдийг тодруулгад өөрөөр зааснаас бусад тохиолдолд Монгол төгрөгөөр, мянганы оронгоор нарийвчилж тайлагнасан.

Санхүүгийн тайлангийн толилуулга

Банк нь санхүүгийн байдлын тайлангийн зүйлсийг хөрвөх чадварынх нь дарааллаар толилуулсан. Санхүүгийн байдлын тайлангийн өдрийн дараах 12 сарын дотор (богино хугацаанд) ба 12 сараас хойших хугацаанд (урт хугацаанд) хүлээн авах эсхүл хийх төлбөрүүдийн талаарх шинжилгээг Тодруулга 29-т толилуулсан.

Банк нь зөвхөн тухайн санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулах хуулиар олгогдсон эрхтэй, мөн санхүүгийн хөрөнгө, санхүүгийн өр төлбөрүүдийг цэвэр дүнгээр нь барагдуулахаар төлөвлөж байгаа, эсхүл хөрөнгийг ашиглаж өр төлбөрийг барагдуулах бол тэдгээр санхүүгийн хөрөнгө болон санхүүгийн өр төлбөрүүдийг санхүүгийн байдлын тайланд цэвэр дүнгээр толилуулах эрхтэй. Нягтлан бодох бүртгэлийн аливаа нэг стандарт эсхүл тайлбараар шаардсан эсхүл зөвшөөрснөөс бусад тохиолдолд орлого, зарлагыг дэлгэрэнгүй орлогын тайланд хооронд нь хааж цэвэр дүнгээр тайлагнаж болохгүй, орлого зардлыг цэвэр дүнгээр нь тайлагнасан тохиолдолд Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогод энэ тухай тусгайлан тодруулна.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд

Банкны санхүүгийн тайланг бэлтгэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайланд орлого ба зардал, хөрөнгө ба өр төлбөр, болзошгүй өр төлбөрийг хүлээн зөвшөөрөх, холбогдох тодруулгуудыг бэлтгэхэд шаардлагатай үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг. Эдгээр тооцоолол, таамаглалын тодорхойгүй байдал нь ирээдүйн тайлант хугацаанд хөрөнгө ба өр төлбөрийн дансны үнэд материаллаг залруулга хийх шаардлагатай болж магадгүй. Банкны нягтлан бодох бүртгэлийн бодлогыг хэрэгжүүлэхийн тулд удирдлага нь санхүүгийн тайлангуудад хүлээн зөвшөөрөх дүнгүүдийг тодорхойлохдоо үнэлэмж, таамаглал тооцооллуудыг хийдэг.

Тооцоолол болон түүнийг хийхэд хэрэглэсэн таамаглал, төсөөллийг тогтмол хянадаг болно. Нягтлан бодох бүртгэлийн тооцоололд хийсэн өөрчлөлтийг зөвхөн нөлөөлж байгаа тайлант үед эсхүл ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд нөлөөлөх бол ирээдүйн болон одоогийн тайлант үеүдэд тус тус тусгадаг. Санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн удирдлагын томоохон үнэлэмж, тооцооллыг дор нэгтгэн харуулав.

2.2 Нягтлан бодох бүртгэлийн гол үнэлэмж, тооцоолол, таамаглалууд (Үргэлжлэл)**Хүлээгдэж буй зээлийн алдагдлын хэмжилт**

Хүлээгдэж буй зээлийн алдагдлыг (ХБЗА) хэмжихэд удирдлага дараах нарийн, чухал тооцоолол болон үнэлэмжийг хийдэг:

- ▶ Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлт: Хүлээгдэж буй зээлийн алдагдал нь 1-р түвшинд хамаарах хөрөнгийн хувьд ирэх 12 сард хамаарах хүлээгдэж буй гарзтай тэнцүү байх ба 2 болон 3-р түвшинд хамаарах хөрөнгийн хувьд уг хөрөнгө төлөгдөж дуусах хугацаа хүртэлх гарзтай тэнцүү байна. Хөрөнгийг анх хүлээн зөвшөөрснөөс хойш зээлийн эрсдэл их хэмжээгээр өссөн үед хөрөнгө 2-р түвшинд шилждэг. Зээлийн эрсдэлийн мэдэгдэхүйц өсөлтийг хэрхэн тодорхойлохыг СТОУС 9-д тусгаагүй. Банк нь хөрөнгийн зээлийн эрсдэлийг мэдэгдэхүйц хэмжээгээр өссөн эсэхийг үнэлэхдээ чанарын болон тоон үзүүлэлт, ирээдүйн эдийн засгийн холбогдох ул үндэслэлтэй мэдээллийг харгалзан үзнэ.
- ▶ Зээлийн эрсдэлийн адил төстэй шинж чанараар хөрөнгийг бүлэглэх: Бүлгийн үнэлгээгээр хүлээгдэж буй гарзыг хэмжихдээ санхүүгийн хэрэгслүүдийн эрсдэлийн адил төстэй шинж чанарт үндэслэн хөрөнгүүдийг бүлэглэнэ. Банк бүлэглэсэн хөрөнгийн зээлийн эрсдэлийн шинж чанар адил төстэй хэвээр байгаа эсэхэд байнга хяналт тавина. Хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанар алдагдсанаар тухайн хөрөнгийг өөр бүлэгт оруулах шаардлага бий болно. Хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанар алдагдсан эсэхийг хянаснаар хөрөнгийн шинэ бүлэг/ багц үүсгэх эсхүл хөрөнгийн эрсдэлийн адил төстэй шинж чанарт үндэслэн тухайн хөрөнгийг тохирох бүлэгт шилжүүлж болно.
Зээлийн эрсдэл мэдэгдэхүйц өсөх (эсхүл зээлийн эрсдэл буурах) үед багцыг дахин бүлэглэх эсхүл багцууд хоорондоо шилжиж болох бөгөөд энэ тохиолдолд 1-р түвшинд хамаарах хөрөнгө 2 болон 3-р түвшинд шилжих эсхүл үүний эсрэгээр шилжих тохиолдол байж болно. Гэхдээ багц хөрөнгийн хувьд өмнө нь хамаарч байсан түвшин хэвээр байгаа боловч багцын эрсдэл өөрчлөгдсөн бол хүлээн зөвшөөрөх эрсдэлийн сангийн хэмжээ өөрчлөгдөнө.
- ▶ Бүтээгдэхүүн бүрийн хувьд ирээдүйн эдийн засгийн төсөөллүүдийн хувилбар болон хувилбаруудын холбогдох жинлэлтийг тооцоолох мөн ирээдүйн эдийн засгийн төсөөллүүдийг тодорхойлох: ХБЗА-г хэмжихдээ Банк зах зээлийн ялгаатай хүчин зүйлсийн нөлөөллөөс ирээдүйд үүсэж бий болох өөрчлөлтийн таамаглалуудыг харгалзсан ул үндэслэлтэй мэдээллийг ашигладаг.
- ▶ Ирээдүйн мэдээлэл: Банкны ХБЗА-ын загвар нь доорх эдийн засгийн өгөгдлүүд дээр суурилсан ирээдүйн мэдээлэл дээр тулгуурладаг. Үүнд:
 - ДНБ
 - ИнфляцИрээдүйн мэдээллийг тусгахдаа Банк эдийн засгийн гурван хувилбарыг авч үздэг (суурь, эерэг ба сөрөг тохиолдол). ХБЗА-ын тооцоололд ашиглаж буй мэдээлэл нь санхүүгийн тайлангийн өдрөөрх зах зээлийн бүх шинж тэмдгийг агуулаагүй байх магадлалтай. Эдгээр ялгаа нь мэдэгдэхүйц материаллаг үед зарим тохиолдолд чанарын тохируулгуудыг түр тохируулгаар хийдэг.
- ▶ Төлбөр төлөгдөхгүй байх магадлал: ТТБМ нь ХБЗЭ тооцох гол үзүүлэлт юм. ТТБМ нь өгөгдсөн хугацаанд төлбөр төлөгдөхгүй байх магадлалыг түүхэн мэдээлэл болон ирээдүйн нөхцөл байдлын таамаглал, хүлээлтүүдийг тус тус харгалзан үзсэний үндсэн дээр тооцоолдог.
- ▶ Алдагдал үүсэх магадлал: АҮМ нь төлбөр төлөх боломжгүй байдлаас үүсэх алдагдлын тооцоолол юм. АҮМ нь гэрээний дагуу хүлээж авах байсан мөнгөн урсгал ба барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг оролцуулан зээлдүүлэгчийн хүлээн авна гэж тооцоолсон дүнгийн зөрүү байна.

Санхүүгийн хэрэгслүүдийн бодит үнэ цэн

Санхүүгийн байдлын тайланд бүртгэгдсэн санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бодит үнэ цэнийг идэвхтэй зах зээл дээрээс олж авах боломжгүй байгаа үед тэдгээрийг математик загваруудыг ашиглах гэх мэт төрөл бүрийн үнэлгээний техникүүдийг ашиглан тодорхойлно. Тэдгээр загварт хэрэглэх өгөгдлүүдийг ашиглах боломжтой зах зээлийн өгөгдлүүдээс гарган авах ба ашиглах боломжтой зах зээлийн өгөгдөл байхгүй тохиолдолд бодит үнэ цэнийг тодорхойлоход үнэлэмж шаардлагатай. Үнэлэмжид төлбөрийн чадвар, урт хугацаат санхүүгийн үүсмэл хэрэгслүүдийн хэлбэлзэл, хорогдуулалтын түвшин, урьдчилгаа төлбөрийн хувь хэмжээ, ТТБМ-ын хувь хэмжээний таамаглалууд гэх мэт мэдээллийг харгалзан үзнэ. Дэлгэрэнгүйг тодруулга 27-оос харна уу.

2.3 Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд**Тайлант жилд хэрэгжиж эхэлсэн шинэ СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартуудын болон нэмэлт өөрчлөлтүүд**

2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс хүчин төгөлдөр болсон доорх СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдээс Банкны хэрэгжүүлж буй нягтлан бодох бүртгэлийн бусад бодлогууд нь өмнөх санхүүгийн жилийнхтэй адил байна. Эдгээр нягтлан бодох бүртгэлийн шинэ стандартуудыг нэвтрүүлсний үр дүн болон өөрчлөлтийн нөлөөг доор тайлбарлав. Нэмэлт өөрчлөлт болон тайлбарыг 2025 оноос анхлан мөрдөж эхлэх боловч Банкны санхүүгийн тайланд нөлөө үзүүлэхгүй юм.

Хэрэв өөрөөр заагаагүй бол шинэ болон нэмэлт өөрчлөлт орсон стандарт, тайлбарууд нь 2025 оны 1 дүгээр сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно. Банк нь батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа нэмэлт өөрчлөлт, стандартын тайлбар болон шинэ стандартыг урьдчилан мөрдөөгүй болно.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2025 оны 1-р сарын 1	НББОУС 21-ын нэмэлт өөрчлөлт – <i>Валютын хөрвөх чадварын дутмаг байдал</i>

НББОУС 21-ийн нэмэлт өөрчлөлт – Валютын хөрвөх чадварын дутмаг байдал

НББОУСЗ өөр валютад хөрвөх чадварын дутмаг байдлын талаарх нэмэлт өөрчлөлтийг НББОУС 21-т 2023 оны 8 сард оруулсан.

Уг нэмэлт өөрчлөлтөөр валют бусад валютад хөрвөх боломжтой эсэхийг хэрхэн тодорхойлох мөн валют бусад валютад хөрвөх боломжгүй үед аж ахуйн нэгж тухайн үеийн ханшийг хэрхэн тодорхойлох талаар тусгаж өгсөн. Валют солих механизм эсхүл валютын зах зээлээс хэрэгжүүлэх боломжтой эрх, үүрэг үүсгэх валют солих ажил гүйлгээгээр, боломжит хугацаанд буюу ажил гүйлгээ хойшлох ердийн хугацааг тооцсон хугацаанд сольсон валютаа хүлээн авах боломжтой тохиолдолд уг валютыг өөр валютад хөрвөх боломжтой гэж үзнэ. Хэрэв тухайн валют нь өөр валютад хөрвөх боломжгүй бол хэмжилтийн өдрөөрх валютын ханшийг тооцох шаардлагатай. Хөрвөх боломжгүй валютын ханшийг тооцоход баримтлах гол зүйл нь ханшийг тооцох өдрөөрх давамгайлах эдийн засгийн нөхцөлд хийгдэж байгаа валют арилжааны ердийн гүйлгээний ханшийг тусгах юм.

Байгууллага нь ажиглагдахуйц буюу ашиглаж болохоор ханш байгаа тохиолдолд уг ханшид залруулга хийхгүйгээр буюу тооцооллын өөр арга техник ашиглахгүйгээр уг ханшийг шууд ашиглах боломжтой гэж нэмэлт өөрчлөлтөд мөн тусгасан.

Байгууллага өөр валютад хөрвөх боломжгүй валютын тухайн үеийн ханшийг тооцоолсон бол санхүүгийн тайлангийн хэрэглэгчдэд тухайн валют нь ямар учраас хөрвөх боломжгүй байгаа мөн энэ нь байгууллагын мөнгөн гүйлгээ, санхүүгийн байдал болон санхүүгийн гүйцэтгэлд хэрхэн нөлөөлөх эсхүл нөлөөлөх магадлалтайг ойлгоход тус дөхөм болох үүднээс эдгээр мэдээллийг санхүүгийн тайланд тодруулна.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлээгүй.

2.3 Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (Үргэлжлэл)**НББОУСЗ-өөс батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд**

Банкны санхүүгийн тайлангуудыг батлан гаргах үед батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд болон стандартын тайлбаруудыг дор тодруулсан болно. Банк эдгээр стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүдийг хэрэгжиж эхлэх үеэс дагаж мөрдөнө.

Хэрэгжих хугацаа	Шинэ стандартууд болон нэмэлт өөрчлөлтүүд
2026 оны 1-р сарын 1	- СТОУС 9 болон СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт - <i>Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал болон үнэлгээний нэмэлт өөрчлөлт</i> - Өөрчлөлт 11- <i>Санхүүгийн тайлагналын олон улсын стандартуудын тухайн жилийн сайжруулалт</i> - СТОУС 9 болон СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт - <i>Эрчим хүч худалдан авах гэрээ</i>
2027 оны 1-р сарын 1	- СТОУС 18 – <i>Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга</i> - СТОУС 19 - <i>Олон нийтэд хамааралгүй охин компаниуд: Тодруулга</i>
Шийдвэрлэгдээгүй	СТОУС 10, НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт - <i>Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан компанийн хооронд худалдсан эсхүл хандивласан хөрөнгө</i>

СТОУС 9 болон СТОУС 7-ын нэмэлт өөрчлөлт - Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал болон хэмжилтийн нэмэлт өөрчлөлт

2024 оны 5-р сарын 30-нд, НББОУСЗ-өөс СТОУС 9 болон СТОУС 7-д нэмэлт өөрчлөлт оруулж “Санхүүгийн хэрэгслүүдийн ангилал болон үнэлгээний нэмэлт өөрчлөлт”-ийг баталсан. Уг өөрчлөлт нь дараах зүйлсийг агуулсан болно:

- ▶ Санхүүгийн өр төлбөрийг “Төлбөр барагдуулах өдөр”-өөр үл хүлээн зөвшөөрөх тодруулга болон “Төлбөр барагдуулах өдөр”-өөс өмнө цахим төлбөрийн систем ашиглан санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрсөн бол ямар нягтлан бодох бүртгэлийн бодлого (тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд) баримталсан тухай танилцуулга
- ▶ Хүрээлэн буй орчин, нийгэм болон байгууллагын засаглал ба түүнтэй төстэй шинж чанартай санхүүгийн хөрөнгийн гэрээний мөнгөн урсгалыг хэрхэн үнэлсэн талаарх нэмэлт зөвлөмж
- ▶ ‘Нөөцөөс хамааралгүй шинж чанар’ гэж юу болох болон гэрээт хэрэгслүүдийн онцлог шинж чанарын талаарх тодруулга
- ▶ Болзошгүй нөхцөлтэй санхүүгийн хэрэгслүүдийн тухай танилцуулга болон БҮЦБДО-д бүртгэх өмчийн хэрэгслүүдийн нэмэлт тодруулгын шаардлагууд

Эдгээр өөрчлөлтүүд нь 2026 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно. Тухайн хугацаанаас өмнө хэрэгжих бол зөвхөн санхүүгийн хөрөнгийн ангилал болон түүнтэй холбоотой тодруулгуудын нэмэлт өөрчлөлтийг хугацаанаас нь өмнө хэрэгжүүлж болно.

Цахим төлбөрийн системээр барагдуулдаг санхүүгийн өр төлбөрийн үл хүлээн зөвшөөрөлттэй холбоотой нэмэлт өөрчлөлтүүдийн хүрээнд, Банк нь эдгээр нэмэлт өөрчлөлтүүд одоогийн практикт мэдэгдэхүйц өөрчлөлт авчрах эсэхийг, мөн төлбөр барагдуулах өдрөөс өмнө эдгээр санхүүгийн өр төлбөрийг үл хүлээн зөвшөөрөхөд баримтлах нягтлан бодох бүртгэлийн бодлого нь тодорхой шаардлагыг хангаж байгаа эсэхийг үнэлэх зорилгоор бусад улс орнуудад ашиглагдаж буй бүх томоохон цахим төлбөрийн системийг судалж байна. Түүнчлэн, Банк нь бусад бүх төлбөрийн системүүдээ (Жишээлбэл: чек, кредит карт, дебит карт) хянаж, холбогдох санхүүгийн өр төлбөрүүдийг төлбөр барагдуулах өдөр үл хүлээн зөвшөөрч байгаа эсэх болон холбогдох санхүүгийн хөрөнгүүдийг мөнгөн орох урсгал дуусмагц данснаас хасаж байгаа эсэхийг тогтмол баталгаажуулж байна.

Мөн Банк нь хүрээлэн буй орчин, нийгэм болон засаглалтай холбоотой болон бусад ижил төрлийн болзошгүй шинж чанар бүхий санхүүгийн хөрөнгүүд, мөн нөөцөөс хамааралгүй санхүүжилт, гэрээт хэрэгслүүдэд эдгээр нэмэлт өөрчлөлтүүдийн үзүүлэх нөлөөг үнэлж байна. Урьдчилсан үнэлгээгээр эдгээр өөрчлөлтүүд санхүүгийн тайланд мэдэгдэхүйц нөлөө үзүүлэхгүй байх гэсэн хүлээлттэй байгаа боловч үнэлгээ эцэслэн хийгдээгүй байна.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

2.3 Шинэ болон шинэчлэгдсэн СТОУС Нягтлан Бодох Бүртгэлийн Стандартууд (Үргэлжлэл)

НББОУСЗ-өөс батлагдсан боловч хэрэгжиж эхлээгүй байгаа стандартууд (Үргэлжлэл)

СТОУС 18 – Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга

2024 оны 4 сард, НББЗ-өөс НББОУС 1 “Санхүүгийн тайлангийн толилуулга”-ыг орлох СТОУС 18 “Санхүүгийн тайлангийн толилуулга ба тодруулга”-ыг баталсан. СТОУС 18 нь Ашиг, алдагдлын тайлангийн тодорхой нийт дүн болон бүлгийн дүнг заасан толилуулгатай холбоотой шинэ шаардлагуудыг тодорхойлсон. Түүнчлэн, компани нь ашиг алдагдлын тайлан дахь бүх орлого болон зардлуудыг дараах таван бүлгийн аль нэгэнд ангилах шаардлагатай болсон. Үүнд: үйл ажиллагааны, хөрөнгө оруулалтын, санхүүжилтийн, орлогын албан татварын болон зогсоосон үйл ажиллагааны гэсэн бүлгүүд хамаарах бөгөөд эхний гурван бүлгийн шинээр нэвтрүүлсэн. “Сайн банк” зэрэг тодорхой үндсэн бизнесийн үйл ажиллагаатай (харилцагчдад санхүүжилт олгодог, тодорхой төрлийн хөрөнгөд хөрөнгө оруулалт хийдэг, эсвэл хослуулдаг) байгууллагуудад зориулсан тусгай толилуулгын шаардлага болон сонголтууд бий.

Мөн уг стандарт нь менежментийн тодорхойлсон гүйцэтгэлийн шинэ үзүүлэлтүүдийг ил тод мэдээлэхийг шаарддаг. Эдгээр нь орлого, зардлын бүлгийн дүнг агуулдаг бөгөөд үндсэн санхүүгийн тайлан болон тодруулгад гүйцэтгэх үүргийг тодорхойлсны үндсэн дээр санхүүгийн мэдээллийг нэгтгэх болон задлах шинэ шаардлагуудыг тусгасан.

СТОУС 7 Мөнгөн гүйлгээний тайланд цар хүрээ багатай өөрчлөлтүүд орсон бөгөөд үүнд шууд бус аргаар үйл ажиллагааны мөнгөн гүйлгээг тодорхойлохдоо эхлэх цэгийг ‘цэвэр ашиг, алдагдал’-аас ‘үйл ажиллагааны ашиг, алдагдал’ болгон өөрчилсөн. Мөн хүү болон ногдол ашгийн мөнгөн гүйлгээг ангилахтай холбоотой сонголтыг халсан. Үүнээс гадна бусад хэд хэдэн стандартад дагалдах өөрчлөлтүүд орсон.

СТОУС 18 болон бусад стандартын өөрчлөлтүүд 2027 оны 1-р сарын 1-ний өдрөөс эсхүл түүнээс хойших тайлант жилүүдэд хүчин төгөлдөр болно. Гэхдээ хугацаанаас нь өмнө хэрэгжүүлэхийг зөвшөөрөх бөгөөд хэрэгжүүлсэн тохиолдолд үүнийг тайланд тусгайлан толилуулах шаардлагатай. СТОУС 18-ийг өмнөх тайлант хугацаанд буцаан мөрдөнө.

Банк нь уг стандартыг хэрэгжүүлэхтэй холбоотойгоор санхүүгийн тайлангууд болон бусад холбогдох тодруулгуудад үзүүлэх нөлөөллийг тодорхойлохоор ажиллаж байна.

СТОУС 10, НББОУС 28-ын нэмэлт өөрчлөлт - Хөрөнгө оруулагч ба түүний хараат компани, хамтарсан үйлдвэрийн хооронд худалдсан эсхүл хуваарилсан хөрөнгө

2015 оны 12 сард, НББЗ-өөс өмчийн аргатай холбоотой судалгааны төслийн үр дүнгээс хамаарах нэмэлт өөрчлөлтийг эцэслэтэл үндсэн нэмэлт өөрчлөлтийг дагаж мөрдөх огноог хойшлуулах шийдвэр гаргасан. Нэмэлт өөрчлөлтийг урьдчилан дагаж мөрдөхийг зөвшөөрсөн хэвээр байна.

Хараат компани, хамтарсан үйлдвэрт худалдах эсхүл хуваарилах байдлаар хяналтыг нь алдсан охин компанийн бүртгэл, тайлагналыг СТОУС 10 Нэгтгэсэн санхүүгийн тайлан болон НББОУС 28 Хараат болон хамтарсан үйлдвэрт оруулсан хөрөнгө оруулалт стандартуудад зөрүүтэй тусгасан байгааг залруулах нэмэлт өөрчлөлтийг оруулсан.

Нэмэлт өөрчлөлтөөр хараат компани болон хамтарсан үйлдвэрт охин компанийг шилжүүлсэн нь СТОУС 3 Бизнесийн нэгдэлд тодорхойлсон бизнес гэсэн ухагдахуунд хамаарах бол шилжүүлэхтэй холбоотой үүссэн олз эсхүл гарзыг бүтэн дүнгээр нь хүлээн зөвшөөрнө гэж тодотгосон. Харин уг шилжүүлэх процесс нь бизнес гэсэн ухагдахуунд хамаарахгүй бол зөвхөн өөрийн хувь эзэмшилд ногдох хэмжээгээр шилжүүлэхтэй холбоотой үүссэн олз эсхүл гарзыг хүлээн зөвшөөрнө.

Энэхүү нэмэлт өөрчлөлт нь Банкны санхүүгийн тайланд материаллаг нөлөө үзүүлэхгүй.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй**Гадаад валютын ханшийн тэгшитгэл**

Банк нь санхүүгийн тайлангаа өөрийн үйл ажиллагааны болон тайлагналын мөнгөн тэмдэгт болох Монгол төгрөгөөр тайлагнадаг. Гадаад валютын гүйлгээг анх бүртгэхдээ гүйлгээ хийсэн өдрийн албан ханшаар үйл ажиллагааны мөнгөн нэгж рүү хөрвүүлж бүртгэнэ. Гадаад валютаар бүртгэсэн мөнгөн хөрөнгө ба өр төлбөрүүдийг санхүүгийн тайлангийн өдрийн албан ханшаар дахин хөрвүүлдэг. Арилжааны бус үйл ажиллагаанаас үүссэн ханшийн бүх зөрүүг дэлгэрэнгүй орлогын тайланд “Үйл ажиллагааны бусад орлого” гэж бүртгэнэ. Түүхэн өртгөөрөө гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлсийг гүйлгээ гарсан өдрийн албан ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээрээ гадаад валютаар хэмжигдэх мөнгөн бус зүйлүүдийг бодит үнэ цэн нь тодорхойлогдсон өдрийн ханшаар хөрвүүлнэ. Бодит үнэ цэнээр бүртгэх мөнгөн бус зүйлүүдийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүг ашиг, алдагдалд шууд бусаар хүлээн зөвшөөрдөг мөнгөн бус зүйлсийн дахин хөрвүүлэлтээс үүссэн ханшийн зөрүүний валютын ханшийн зөрүүг бусад дэлгэрэнгүй орлогод шууд хүлээн зөвшөөрдөг.

Орлого ба зардлыг хүлээн зөвшөөрөх

Эдийн засгийн өгөөж нь Банканд орж ирэх нь тодорхой мөн хэмжих боломжтой үед орлогыг хүлээн зөвшөөрч бүртгэдэг. Орлогыг хүлээн зөвшөөрөхөөс өмнө дараах тусгай шалгуурууд хангагдсан байх ёстой. Үүнд:

(i) Хүүгийн цэвэр орлого

Арилжаалах зорилгоор эзэмшиж байгаа эсхүл БҮЦАА бүртгэхээс бусад тохиолдолд санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого ба зардлыг үр ашигт хүүгийн аргаар тооцоолон "Хүү болон түүнтэй адилтгах орлого" ба "Хүү болон түүнтэй адилтгах зардал" гэж хүлээн зөвшөөрч цэвэр хүүгийн орлогод тус тус бүртгэнэ. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүг тайлант хугацааны бодит үнэ цэнийн өөрчлөлт гэж үзэх бөгөөд "Арилжааны цэвэр орлого/алдагдал" болон "Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг ашиг алдагдалд бүртгэх бусад санхүүгийн хэрэгслүүдийн цэвэр орлого"-д толилуулна. Бодит үнэ цэнийн өөрчлөлтийг бусад дэлгэрэнгүй орлогод бүртгэх санхүүгийн хэрэгслүүд болон хорогдуулсан өртгөөр бүртгэх санхүүгийн хэрэгслүүдийн хүүгийн орлого эсхүл зардлыг үр ашигт хүүгийн арга ашиглан тооцоолно.

Үр ашигт хүүгийн түвшин нь ирээдүйн мөнгөн урсгалыг санхүүгийн хэрэгслүүдийн хүлээгдэж буй хугацаанд эсхүл түүнээс богино хугацааны туршид хорогдуулж санхүүгийн хөрөнгө, өр төлбөрийн дансны цэвэр дүнг гаргах хүүгийн хувь болно. Ирээдүйн мөнгөн урсгалыг тооцохдоо санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний бүх нөхцөлүүдийг харгалзан үзнэ.

Тооцоолохдоо санхүүгийн хэрэгслүүдийн гэрээний бүх нөхцөлүүд (жишээлбэл, урьдчилж төлөх сонголт) болох ирээдүйн зээлийн алдагдлаас бусад тухайн хэрэгслүүдэд шууд хамаарах аливаа төлбөр эсхүл өсөн нэмэгдэх зардал болон үр ашигт хүүгийн түвшнийг харгалзан үзнэ.

Үнэ цэн нь буурсан санхүүгийн хөрөнгийн үр ашигт хүү нь ирээдүйн мөнгөн урсгалыг (хүлээн зөвшөөрөх үед хүлээгдэж буй эрсдэлийн санг оруулна) санхүүгийн хөрөнгийг анх хүлээн зөвшөөрөх үеийн бодит үнэ цэнтэй (ихэнх тохиолдолд худалдан авсан дүнтэй тэнцүү байна) нь тэнцүү болгон хорогдуулах хүү байна. Энэхүү тооцооллоор үр ашигт хүүгийн түвшин өөрчлөгдөнө.

Доор дурдсан 2 нөхцөлөөс бусад тохиолдолд санхүүгийн хөрөнгийн дансны нийт дүнгээс үр ашигт хүүгийн хэмжээгээр хүүгийн орлого тооцоолно. (i). Үнэ цэнийн бууралтад орсон (3-р түвшинд хамаарах) санхүүгийн хөрөнгийн хүүгийн орлогыг дансны нийт үнээс эрсдэлийн санг хассан дүнд үндэслэн үр ашигт хүүгийн хувиар тооцоолон олно. (ii). Үнэ цэнийн бууралттай санхүүгийн хөрөнгө худалдан авсан эсхүл санхүүгийн хөрөнгийг анх гаргахад үнэ цэнийн бууралтад орсон бол тухайн хөрөнгийн хорогдуулсан өртөгт үндэслэн эрсдэлээр тохируулсан хүүгийн хувь хэмжээгээр хүүгийн орлогыг тооцоолно.

(ii) Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого

Банк нь өөрийн харилцагч нарт үзүүлдэг төрөл бүрийн үйлчилгээнээс хураамж, шимтгэлийн орлого олдог. Хураамж, шимтгэлийн орлогыг тухайн үйлчилгээг үзүүлсний хариуд Банкны олох төлбөрийн хэмжээг тусгасан хэмжээгээр хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн үүрэг, түүнчлэн тэдгээрийг хангах хугацааг гэрээ байгуулах үед тодорхойлдог. Банкны орлогын гэрээнд доор тайлбарласны дагуу олон гүйцэтгэлийн үүрэг ихэвчлэн байдаггүй. Банк нь харилцагчдаа үйлчилгээ үзүүлэх үед төлбөрийг нэхэмжлэх бөгөөд ихэнхдээ үйлчилгээ үзүүлсэн даруй эсхүл тодорхой хугацаанд үзүүлсэн үйлчилгээний төлбөрийг гэрээний хугацаа дууссаны дараа авдаг. Банк нь үйлчилгээгээ харилцагчид шилжүүлэхээс өмнө ихэвчлэн хяналт тавьдаг тул орлогын зохицуулалтын үндсэн үүрэг гэж дүгнэсэн.

2.4 Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогын хураангуй (Үргэлжлэл)

Орлого ба зардлыг хүлээн зөвшөөрөх (Үргэлжлэл)

(ii) Хураамж ба шимтгэлийн цэвэр орлого (Үргэлжлэл)

Санхүүгийн үйлчилгээ үзүүлсэн хугацааны туршид хүлээн зөвшөөрсөн хураамж, шимтгэлийн орлого

Тодорхой хугацааны туршид үйлчилгээг үзүүлж олох орлогыг тэр хугацааны туршид нь хуримтлуулна. Эдгээр хураамжид хадгаламжийн хайрцгийн шимтгэл орно.

Гүйлгээний үйл ажиллагаанаас олсон шимтгэлийн орлого

Гуравдагч этгээдтэй хийсэн хэлцэл, хэлцэлд оролцсоноос үүссэн хураамжийг үндсэн хэлцэл дууссаны дараа хүлээн зөвшөөрнө. Гүйцэтгэлийн тодорхой үүрэг хариуцлагатай холбоотой хураамж буюу хураамжийн бүрэлдэхүүн хэсгүүдийг гүйцэтгэлийн холбогдох шалгуурыг хангасны дараа хүлээн зөвшөөрнө.

Банк нь өргөн цар хүрээний санхүүгийн үйлчилгээ үзүүлж үүнээсээ шимтгэл ба хураамж авдаг. Банк санхүүгийн үйлчилгээ үзүүлснээр үр ашигт өгөөжийн нэг хэсэг биш болох бүх шимтгэлийн орлогоо (төлбөрийн картын хураамж, гар утасны үйлчилгээ г.м) цаг тухайд нь гүйцэтгэл биелэгдсэн үед нь бүртгэдэг. Банк өөрийн зээлийн багцын хэсэг болон бусад оролцогчдод хамаарах үр ашигт хүүгийн хэсгүүдээс өөртөө авч үлдээгүй.

- **Зээлийн Удирдлагын Хороо** нь нэг болон хоёрдугаар хамгаалалтын бүсүүдийн зээл шийдвэрлэх эрхийн хүрээнээс давсан зээл болон эрсдэлийн саналыг хэлэлцэн шийдвэрлэх чиг үүрэгтэй болно.
- **Үйл Ажиллагааны Эрсдэлийн Удирдлагын Хороо** нь Банкны хяналтад суурилсан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагын тогтолцооны хэрэгжилтийг хянах, үйл ажиллагааны эрсдэлийг удирдах чиг үүрэгтэй болно.

Эрсдэлийн цар хүрээ, төрөл

Банк эрсдэл бүрд холбогдох хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлдог бөгөөд учирч болох эрсдэлийн цар хүрээг төрлүүдээр нь дараах байдлаар тодорхойлсон. Үүнд:

- **Зээлийн эрсдэл**, зээлдэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлж чадаагүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал;
- **Зээлийн төвлөрлийн эрсдэл**, хэт их зээлийн төвлөрлийн улмаас үүсэх алдагдал;
- **Зах зээлийн эрсдэл**, зах зээлийн үнийн өөрчлөлтөөс орлого болон хөрөнгийн хэмжээнд хүлээж болзошгүй алдагдал;
- **Өөрийн хөрөнгийн хүрэлцээний эрсдэл**, хязгаарлагдмал өөрийн хөрөнгийн улмаас бизнесийн үйл ажиллагааг үргэлжлүүлэх чадваргүй болох эсвэл зохицуулагч байгууллагын өөрийн хөрөнгийн хүрэлцээний шаардлагыг хангаж чадахгүй болох;
- **Хөрвөх чадварын эрсдэл**, хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн дутагдалд орох болон хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох;
- **Үйл ажиллагааны эрсдэл** (авлига, залиланг оролцуулан), дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсвэл гаднын хүчин зүйлсийн (үүнд эрх зүйн эрсдэлийг оролцуулан) улмаас үүсэх хүлээж болзошгүй алдагдал;

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.1 Оршил (Үргэлжлэл)

Эрсдэлийн цар хүрээ, төрөл (Үргэлжлэл)

- **Мэдээллийн аюулгүй байдлын эрсдэл**, мэдээлэл алдагдах, мэдээллийн системд халдлага хийх эсхүл түүнийг зөрчсөний улмаас үүсэх гарз хохирол болон алдагдал;
- **Ёс зүйн эрсдэл**, банкны ёс зүйн дүрмийг зөрчсөн эсхүл харилцагчидтай шударга харилцах зарчмыг баримтлаагүйн улмаас хүлээж болзошгүй алдагдал;
- **Хянан нийцүүлэлтийн эрсдэл**, хянан нийцүүлэлтийг хангаж ажиллаагүйн улмаас үүсэх алдагдал;
- **Нэр хүндийн эрсдэл**, банкны нэр хүндэд хохирол учрах, улмаар орлогын хэмжээнд алдагдал үүсэх эрсдэл;
- **Стратегийн эрсдэл**, банкны стратегийг оновчтой төлөвлөж чадаагүйн улмаас ашигтай ажиллах, орлого олох боломжоо алдах эрсдэл.

Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ, Стресс тест, Эрсдэлийн тайлагнал

Банкны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ нь Банкны бизнес төлөвлөгөөтэй уялдсан байдаг бөгөөд дараах нэр томъёог ашигладаг. Үүнд:

- **Эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээ** гэдэгт Банк стратеги зорилт болон бизнесийн төлөвлөгөөндөө хүрэхэд эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг;
- **Эрсдэлийн хязгаар** гэдэгт Банкны эрсдэлийг хүлээн зөвшөөрөх хэм хэмжээг үр дүнтэй хэрэгжүүлэх үзүүлэлтийг;
- **Эрсдэл даах чадвар** гэдэгт зохицуулагч байгууллагын тавьсан хязгаарлалтын хүрээнд Банкны хүлээж чадах эрсдэлийн хэмжээг;
- **Стресс гүйцэтгэл** гэдэгт урьдчилж тодорхойлогдсон стресс нөхцөлүүдэд хүлээн зөвшөөрөх санхүүгийн гүйцэтгэлийг хэлнэ.

Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь эрсдэлийн төрлүүдийн хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажилладаг. Банк санхүүгийн гүйцэтгэл болон төлөвлөлтийг хөнгөн болон хүнд уналтын гэсэн хоёр цочролын сценариудад үнэлэхээс гадна эдгээр сценариудад ороогүй бусад нөхцөлүүдийн хувьд болзошгүй эрсдэлийн сценари болон шинжилгээгээр Банкны эрсдэл даах чадварыг мөн үнэлдэг болно.

31.2 Зээлийн эрсдэл

Банкны зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам нь Банкны зээлийн эрсдэлийн удирдлагын тогтолцоог тодорхойлох, хүлээн зөвшөөрөх зээлийн эрсдэлийн хэм хэмжээ, эрсдэлийн хязгаар болон Монгол Улсын холбогдох хууль тогтоомжийн хүрээнд зээлийн эрсдэлийг зохистой удирдах ерөнхий зарчим болон үйл ажиллагааг тодорхойлж зохицуулдаг.

Банкны зээлийн эрсдэлийн тогтолцооны хүрээнд, бизнесийн нэгж нь харилцагчаа сонгох, тэдгээрт тохирсон бүтээгдэхүүн, үйлчилгээ, нөхцөлийг санал болгох, тэдгээрийн зээл төлөх чадварыг үнэлэх, зээлийн гэрээний үүргийг хангуулахаар барьцаалах хөрөнгийг үнэлэх, зээлийг төлүүлэх, хянах, анхаарал татсан зээлийг илрүүлэх, эрсдэлтэй зээлийг төлүүлэхтэй холбоотойгоор шаардлагатай арга хэмжээг авах чиг үүрэгтэй байна.

Эрсдэл хариуцсан нэгж нь зээлийн үйл ажиллагаатай холбоотой ерөнхий үйл ажиллагааны журмыг боловсруулах, зээлийн эрсдэлтэй холбоотой хязгаарууд, хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тогтоох, батлуулах, зээлийн эрсдэлийг хянах болон бизнесийн нэгжийн үйл ажиллагаанд хяналт тавьж, заавар зөвлөмжөөр ханган ажиллах чиг үүрэгтэй байна.

Банк санхүүгийн хөрөнгийн хүлээгдэж буй алдагдлыг СТОУС 9-ийн дагуу бүлгийн болон тусгайлсан үнэлгээ хийж шинжилдэг.

Тусгайлсан үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын хасагдуулга

Банк нь өндөр дүнтэй зээл ба урьдчилгаанд нэг бүрчлэн зээлийн эрсдэлийн тохирох санг тооцдог. Зээлийн үнэ цэнийн бууралтын хэмжээг тодорхойлоход зээлдэгчийн бизнес төлөвлөгөөний тогтвортой байдал, санхүүгийн хүндрэл тохиолдсон үед гүйцэтгэлээ сайжруулах чадвар, дампуурал тохиолдсон үед хүлээн авах төлбөрүүд болон хүлээгдэж буй ногдол ашгийн төлбөрүүд, санхүүгийн өөр бусад дэмжлэг авах боломжууд, барьцаа хөрөнгийн бодит үнэ цэн, хүлээгдэж буй мөнгөн урсгалын хугацаа зэргийг зайлшгүй авч үздэг. Үнэ цэнийн бууралтаас үүсэх алдагдлын хэмжээг, гэнэтийн үйл явдлуудын улмаас илүү нухацтай авч үзэх шаардлагатай байгаагаас бусад тохиолдолд тухай бүр тайлант өдрөөр үнэлнэ.

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****Бүлгийн үнэлгээгээр үнэлсэн үнэ цэнийн бууралтын хасагдуулга**

Дангаараа чухал ач холбогдолгүй бүх зээл ба урьдчилгаа болон дангаараа чухал ач холбогдолтой боловч тусгайлсан үнэлгээгээр үнэ цэн бууралтын бодит нотолгоо гарч ирээгүй зээл ба урьдчилгаануудыг бүлэглэн, бүлэг тус бүр дээр хүлээж болзошгүй алдагдлыг тооцно. Удирдлагын зүгээс бүлгийн үнэлгээг хагас жил тутамд бүлэг тус бүрд ялгаатай шинжилгээнд үндэслэн хийнэ.

Бүлгийн үнэлгээнд тусгайлсан үнэлгээгээр үнэ цэнийн бууралтын бодит нотолгоо байхгүй боловч тэдгээрийг багтаасан багцын түвшинд оршин байх магадлал бүхий үнэ цэнийн бууралтыг тооцдог. Хүлээгдэж буй алдагдлын хэмжээг хүлээгдэж буй эдийн засгийн нөхцөл байдал, шатлалын зэрэглэл тус бүрийн төлбөр төлөгдөхгүй байх магадлал (ТТБМ) болон алдагдал үүсэх магадлал (АҮМ)-д үндэслэн тогтоодог.

Банк нь эдийн засгийн өнөөгийн байдал болон эдийн засгийн төлөвийг харгалзан ирэх 12 сарын хугацааны төлбөр төлөгдөхгүй байх магадлал (ТТБМ) болон алдагдал үүсэх магадлал (АҮМ)-ын хувь хэмжээг тооцоолдог. ДНБ-ний өсөлт болон төлбөр төлөгдөхгүй байх магадлал хоорондын хамаарал өндөр байдаг тул төлбөр төлөгдөхгүй байх магадлал (ТТБМ) болон алдагдал үүсэх магадлал (АҮМ)-ын параметруудийг эдийн засгийн төлөв байдалтай уялдуулан жигнэн тооцсон хувь нь ирээдүйн макро эдийн засгийн төлөв байдлыг тусгасан байдаг.

Банк үнэ цэнийн бууралтын шатлалын түвшнийг дараах байдлаар тодорхойлдог. Үүнд:

Түвшин 1: Хэвийн багцад Монголбанкны холбогдох журмын дагуу хэвийн ангилалтай ба 30 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн хөрөнгүүд хамаарна. Эдгээр хөрөнгийн хувьд ирэх 12 сарын хугацаанд хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тооцно.

Түвшин 2: Чанар нь муудаж буй багцад 31-ээс 90 хүртэл хоногоор хугацаа хэтэрсэн, бүтэц өөрчилсөн болон ангилал нь хэвийн боловч дотоодын үнэлгээгээр анхаарал татаж буй хөрөнгүүд хамаарна. Эдгээр хөрөнгүүдийн хувьд гэрээний хугацаанд хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тооцно.

Түвшин 3: Чанар нь муудсан багцад Монголбанкны холбогдох журмын дагуу хэвийн бус, эргэлзээтэй болон муу ангилалтай буюу чанаргүй ангилалтай хөрөнгүүд хамаарна. Эдгээр хөрөнгүүдийн хувьд гэрээний хугацаанд хүлээгдэж буй алдагдлын хэмжээг тооцно.

Эрсдэл хариуцсан захирал болон Санхүү хариуцсан захирал нь зээлийн үнэ цэн бууралтын сан нь Банкны бодлоготой нийцэж байгаа эсэхэд хяналт тавьж ажилладаг.

Зээлийн эрсдэлийн стресс тест

Төлбөр төлөгдөхгүй байх магадлал (ТТБМ)-ын түүхэн мэдээлэл дээр үндэслэн эконометрикийн арга хэрэгсэл ашиглан Банкны ирээдүйн макро эдийн засгийн загварыг боловсруулж үнэ цэнийн бууралтыг тооцоход ашигладаг. Үүнд 2011-2025 оны улирлын голлох макро индикаторууд болон Банкны өмнөх түүхэн хугацааны ТТБМ-н мэдээллийг ашигласан. Макро индикаторуудыг Үндэсний статистикийн хорооноос, ТТБМ-г Банкны дотоод мэдээллийн сангаас авдаг бөгөөд ТТБМ-н хувьтай хамгийн өндөр хамааралтай макро эдийн засгийн голлох үзүүлэлтүүдийг загварт сонгож ашигласан. Мөн боломжит үр дагавруудыг үнэлэхийн тулд банк макро эдийн засгийн төлөв байдлын гурван хувилбарыг ашигладаг. Макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл болон ирээдүйд тохиолдож болох нөхцөл байдлуудын магадлалд үндэслэн суурь, өөдрөг болон гутранги үеийн эдийн засгийн таамаглалыг боловсруулдаг. Уг таамаглалыг Эрсдэлийн загвар шинжилгээний хэлтэс хариуцан хийж гүйцэтгэдэг.

Стресс тестийг дээр дурдсан макро эдийн засгийн таамаглалд үндэслэн хувилбар тус бүрд харгалзах хувийн жинг өөрчлөх замаар суурь, өөдрөг болон гутранги нөхцөлд ирээдүйн ТТБМ-г авах бөгөөд ХБЗА тооцооллыг ашиглан үр дүнг тооцсон.

ХБЗА-г тооцохдоо Монголбанк болон олон улсын байгууллагуудаас гаргасан таамаглалуудын дундажыг ашиглан Монгол Улсын эдийн засгийн өсөлт 2026 онд ойролцоогоор 6.5% байна гэсэн суурь нөхцөлтэйгөөр хувийн жингүүдийг гутранги таамаглал 40%, суурь таамаглал 50% болон өөдрөг таамаглал 10% байхаар авч үзсэн. Таамаглалын гутранги хувилбарт эдийн засгийн өсөлт ойролцоогоор 3.0%, хувийн жинг 100% байхаар тооцсон бол өөдрөг хувилбарт эдийн засгийн өсөлт 2026 онд 8.0% орчим байх нөхцөлтэйгөөр эерэг таамаглалын хувийн жинг 100% байхаар тооцоолсон.

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга 2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Зээлийн эрсдэлийн стресс тест (Үргэлжлэл)

Доорх хүснэгтэд макро эдийн засгийн өнөөгийн нөхцөл болон ирээдүйд тохиолдож болох нөхцөл байдлуудын магадлалд үндэслэн суурь, өөдрөг болон гутранги үеийн стресс тестийн үр дүнг харуулсан бөгөөд 2025 оны 12 сарын 31-ээрх зээлийн үнэ цэнийн бууралтын сангийн хэмжээг суурь нөхцөлөөр сонгосон.

Сан мян.төг	Зээл мян.төг	Санхүүгийн түрээс мян.төг	Зээлийн үнэ цэнэ бууралтын сан мян.төг	Өөрчлөлт мян.төг
Эерэг таамаглал	43,644,362	946,031	44,590,393	26,644,879
Суурь таамаглал	68,340,575	2,894,697	71,235,272	-
Сөрөг таамаглал	82,165,266	4,055,907	86,221,173	(14,985,901)

Доорх хүснэгтэд хөрөнгийн түвшин тус бүрийн хүлээгдэж буй алдагдал болон түвшин хоорондын шилжилт хөдөлгөөнийг харуулав.

Хорогдуулсан өртгөөрх бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж

	2025 Нийт Түвшин 1 мян.төг	2024 Нийт Түвшин 1 мян.төг
1-р сарын 1-нээр	776,456,708	394,238,579
Шинээр үүссэн	383,426,008	730,367,365
Хугацаа дуусаж данснаас хассан	(716,129,577)	(348,149,236)
12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	443,753,139	776,456,708
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга		
1-р сарын 1-нээр	359,940	469,515
Тайлант жилд буцаасан (Тодруулга 9)	79,313	(109,575)
12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	439,253	359,940

Үнэ цэнийн бууралтад үндэслэсэн хорогдуулсан өртгөөрх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	Түвшин 1 12 сараар мян.төг	Түвшин 2 Дуусах хугацаагаар мян.төг	Түвшин 3 Дуусах хугацаагаар мян.төг	Нийт мян.төг
2025 оны 12-р сарын 31-нээр				
2025 оны 1-р сарын 1-нээр	3,397,723,092	58,812,404	74,965,903	3,531,501,399
Шинээр нэмэгдсэн	2,426,636,471	-	-	2,426,636,471
- Түвшин 1-с шилжүүлсэн	(64,970,833)	25,528,545	39,442,288	-
- Түвшин 2-с шилжүүлсэн	11,916,305	(29,103,869)	17,187,564	-
- Түвшин 3-с шилжүүлсэн	377,494	299,434	(676,928)	-
Хугацаа дуусаж данснаас хассан	(1,819,458,122)	(23,744,450)	(26,126,855)	(1,869,329,427)
Сангаас хаасан	-	-	(922,959)	(922,959)
2025 оны 12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	3,952,224,407	31,792,064	103,869,013	4,087,885,484

ХАСБАНК ХК

**Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31**

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Үнэ цэнийн бууралтад үндэслэсэн хорогдуулсан өртгөөрх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа (Үргэлжлэл)

	Түвшин 1 12 сараар мян.төг	Түвшин 2 Дуусах хугацаагаар мян.төг	Түвшин 3 Дуусах хугацаагаар мян.төг	Нийт мян.төг
2025 оны 12-р сарын 31-нээр				
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга				
2025 оны 1-р сарын 1-нээр	15,744,632	1,504,240	41,517,524	58,766,396
Шинээр нэмэгдсэн	13,620,568	-	-	13,620,568
- Түвшин 1-с шилжүүлсэн	(4,109,826)	251,574	3,858,252	-
- Түвшин 2-с шилжүүлсэн	615,654	(1,083,008)	467,354	-
- Түвшин 3-с шилжүүлсэн	367,178	215,287	(582,465)	-
Хугацаа дуусаж данснаас хассан	(7,858,901)	(211,973)	(13,015,405)	(21,086,279)
Сангаас хаасан	-	-	(922,959)	(922,959)
Түвшин хоорондын шилжилт болон өгөгдөл, моделийн өөрчлөлтийн нөлөө	(1,737,103)	66,379	22,529,400	20,858,676
2025 оны 12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	16,642,202	742,499	53,851,701	71,236,402
2024 оны 12-р сарын 31-нээр				
2024 оны 1-р сарын 1-нээр	2,552,502,183	54,848,802	82,369,026	2,689,720,011
Шинээр нэмэгдсэн	2,438,644,827	-	-	2,438,644,827
- Түвшин 1-с шилжүүлсэн	(71,288,460)	48,028,027	23,260,433	-
- Түвшин 2-с шилжүүлсэн	1,226,746	(3,444,143)	2,217,397	-
- Түвшин 3-с шилжүүлсэн	1,269,598	61,308	(1,330,906)	-
Хугацаа дуусаж данснаас хассан	(1,524,631,802)	(40,681,590)	(29,788,583)	(1,595,101,975)
Сангаас хаасан	-	-	(1,761,464)	(1,761,464)
2024 оны 12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	3,397,723,092	58,812,404	74,965,903	3,531,501,399
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга				
2024 оны 1-р сарын 1-нээр	12,731,387	5,688,897	44,065,317	62,485,601
Шинээр нэмэгдсэн	15,703,106	-	-	15,703,106
- Түвшин 1-с шилжүүлсэн	(5,346,667)	695,379	4,651,288	-
- Түвшин 2-с шилжүүлсэн	49,865	(276,875)	227,010	-
- Түвшин 3-с шилжүүлсэн	1,036,392	40,114	(1,076,506)	-
Хугацаа дуусаж данснаас хассан	(6,846,910)	(3,330,957)	(15,220,096)	(25,397,963)
Сангаас хаасан	-	-	(1,761,464)	(1,761,464)
Түвшин хоорондын шилжилт болон өгөгдөл, моделийн өөрчлөлтийн нөлөө	(1,582,541)	(1,312,318)	10,631,975	7,737,116
2024 оны 12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	15,744,632	1,504,240	41,517,524	58,766,396

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд

	2025 Нийт Түвшин 1 мян.төг	2024 Нийт Түвшин 1 мян.төг
1-р сарын 1-нээр	1,135,152,483	961,193,681
Шинээр нэмэгдсэн	1,088,830,067	1,135,074,359
Хугацаа дуусаж данснаас хассан	(1,120,114,127)	(961,115,557)
12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	1,103,868,423	1,135,152,483
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга		
1-р сарын 1-нээр	1,260,203	1,123,057
Тайлант жилд байгуулсан (Тодруулга 9)	569,608	1,259,814
Тайлант жилд буцаасан (Тодруулга 9)	(1,178,753)	(1,122,668)
12-р сарын 31-ний байдлаарх дансны үнэ	651,058	1,260,203

Барьцаа хөрөнгө болон бусад зээлийн баталгаа, батлан даалтыг тооцохгүйгээр зээлд учирч болзошгүй эрсдэлийн дээд хэмжээг авч үзвэл:

Доорх хүснэгт нь санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт бүрийн хувьд зээлийн эрсдэлд өртөж болох нийт багцыг харуулсан байна. Эрсдэлд өртөж болох нийт багцыг барьцаа хөрөнгөөр эрсдэлийг бууруулахаас өмнөх нийт дүнгээр илэрхийлсэн болно.

	2025 мян.төг	2024 мян.төг
Ангилал тус бүрээр		
Хорогдуулсан өртгөөрх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	4,087,885,484	3,531,501,399
Хорогдуулсан өртгөөрх Монголбанк болон бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж	1,151,563,673	1,175,462,516
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд	1,103,868,423	1,135,152,483
Зээл, түүнтэй адилтгах хүлээж болзошгүй үүрэг	209,817,695	175,079,999
Болзошгүй өр төлбөр	92,331,704	94,405,513
Бусад санхүүгийн хөрөнгө	14,493,027	21,322,870
Нийт	6,659,960,006	6,132,924,780

Бодит үнээр бүртгэгддэг санхүүгийн хэрэгслүүдийн хувьд дээрх дүнгүүд нь өнөөгийн зээлийн эрсдэлийн өртөлтийг харуулсан ба энэ нь ирээдүйд үнэ цэн өөрчлөгдөхөөс шалтгаалж бий болж болох эрсдэлийн дээд хэмжээ харуулаагүй болно.

Эрсдэлийн төвлөрөл эдийн засгийн салбараар

Доорх хүснэгтэд Банкны санхүүгийн хөрөнгийг эдийн засгийн салбарын зорилгоор нь ангилан, нийт дүнгээр (зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнийг авч үзэхээс өмнөх болон дараах дүнгээр) нь үзүүлэв.

Хорогдуулсан өртгөөрх Монголбанк болон бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж

	2025 мян.төг	%	2024 мян.төг	%
Эдийн засгийн салбар				
Төвбанк	1,063,713,052	92.4	743,390,401	63.2
Арилжааны банк	87,850,621	7.6	432,072,115	36.8
Нийт	1,151,563,673	100.0	1,175,462,516	100.0

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

Хорогдуулсан өртгөөрх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

	2025		2024	
Эдийн засгийн салбар	мян.төг	%	мян.төг	%
Худалдаа	1,103,824,147	27.1	825,155,243	23.4
Хэрэглээ	671,019,535	16.4	812,342,249	23.0
Хадгаламж барьцаалсан	553,603,156	13.5	470,750,200	13.3
Бусад	414,915,569	10.1	421,707,143	11.9
Үйлдвэрлэл	402,916,147	9.9	295,694,682	8.4
Орон сууц	348,728,225	8.5	227,562,067	6.4
Үйлчилгээ	256,571,364	6.3	189,502,430	5.4
Барилга	167,144,925	4.1	142,151,867	4.0
Уул уурхай	134,631,657	3.3	123,647,153	3.5
Хөдөө аж ахуй	34,530,759	0.8	22,988,365	0.7
Нийт	4,087,885,484	100.0	3,531,501,399	100.0

Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд

	2025		2024	
Эдийн засгийн салбар	мян.төг	%	мян.төг	%
Төвбанк	1,091,328,149	98.9	1,135,074,359	100.0
Байгууллага	12,540,274	1.1	78,124	0.0
Нийт	1,103,868,423	100.0	1,135,152,483	100.0

Зээл, түүнтэй адилтгах хүлээж болзошгүй үүрэг

	2025		2024	
Эдийн засгийн салбар	мян.төг	%	мян.төг	%
Иргэд				
Бичил бизнесийн зээл	19,715,494	9.4	14,964,172	8.6
Бизнесийн зээл	44,593,748	21.3	30,014,952	17.1
Барьцаагүй зээл	17,968,487	8.6	18,930,859	10.9
ЖДҮ ба байгууллага				
Уул уурхай	61,544,896	29.3	56,620,523	32.3
Худалдаа	47,050,747	22.4	25,355,596	14.5
Үйлдвэрлэл	10,984,898	5.2	10,580,971	6.0
Бусад	6,924,425	3.3	18,212,576	10.4
Үйлчилгээ	1,035,000	0.5	400,000	0.2
Барилга	-	-	350	-
Нийт	209,817,695	100.0	175,079,999	100.0

Санхүүгийн баталгаа (Эх үүсвэргүй)

	2025		2024	
Баталгаа	мян.төг	%	мян.төг	%
Худалдаа	22,591,865	24.5	32,028,376	33.9
Уул уурхай	19,691,278	21.3	2,220,229	2.4
Үйлчилгээ	16,865,142	18.3	31,339,665	33.2
Барилга	15,048,973	16.3	15,168,105	16.1
Үйлдвэрлэл	14,811,062	16.0	11,216,224	11.9
Бусад	2,984,132	3.2	1,292,975	1.3
Хөдөө аж ахуй	339,252	0.4	1,139,939	1.2
Нийт	92,331,704	100.0	94,405,513	100.0

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Зээлийн барьцаа хөрөнгө

Зээлдэгч буюу харилцагчийн зээлийн эрсдэлийн үнэлгээ болон тэдгээрт олгох зээлийн төрлөөс хамааран барьцаа хөрөнгийн шаардлагыг тодорхойлдог. Банкны зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам нь барьцаалах эд хөрөнгийн төрөл болон тэдгээрийн зээлд зөвшөөрөх хувийг тодорхойлсон байдаг.

Банкны барьцаалах эд хөрөнгийн гол төрлүүдийг дор үзүүлэв. Үүнд:

- (i) Үл хөдлөх эд хөрөнгийн хувьд барилга, байгууламж, хашаа байшин (газрын хамт) болон газар;
- (ii) Хөдлөх хөрөнгийн хувьд тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж, харилцах хадгаламж, мал, бараа материал, баталгаа, батлан даалт болон биет бус хөрөнгө.

Банк нь барьцаа хөрөнгүүдийн биет байдал болон зах зээлийн үнийг тогтмол хянадаг. Зээлийн эрсдэлийн сангийн хүрэлцээг тооцохын тулд барьцаа хөрөнгийн зах зээлийн үнийг хянадаг ба шаардлагатай бол гэрээнд заасны дагуу нэмэлт хөрөнгө барьцаалдаг.

Зээлийн барьцаа
хөрөнгийн төрөл:

Зээлийн барьцаа хөрөнгийн бодит үнэ цэн

	Зээлийн эрсдэлд өртөж болох нийт багц мян.төг	Үл хөдлөх хөрөнгө мян.төг	Бараа материал мян.төг	Тээврийн хэрэгсэл мян.төг	Хадгаламж мян.төг	Тоног төхөөрөмж мян.төг	Бусад мян.төг	Нийт барьцаа мян.төг	Өртөж болох цэвэр багц мян.төг	Багцад хамаарах барьцаа хөрөнгийн шаардлагын хувь	Үнэ цэнийн бууралтын хасагдуулга мян.төг
2025 оны 12-р сарын 31-ний байдлаар											
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа											
Байгууллагын зээл	815,563,660	876,736,244	841,538,500	37,128,037	-	69,997,984	-	1,825,400,765	(1,009,837,105)	223.80%	3,724,154
Жижиг бизнесийн зээл	1,731,517,413	1,958,303,894	187,209,402	1,290,791,712	46,048,436	17,964,740	2,997,553	3,503,315,737	(1,771,798,324)	202.30%	27,729,337
Хэрэглээний зээл	1,192,076,186	48,349,296	27,000	30,075,377	734,173,843	18,000	-	812,643,516	379,432,670	68.20%	35,960,767
Орон сууцны ипотекийн зээл	514,083,904	895,738,284	700	479,795	175,269	-	-	896,394,048	(382,310,144)	174.40%	3,822,144
Нийт	4,253,241,163	3,779,127,718	1,028,775,602	1,358,474,921	780,397,548	87,980,724	2,997,553	7,037,754,066	(2,784,512,903)		71,236,402

2024 оны 12-р сарын 31-ний байдлаар

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа

Байгууллагын зээл	636,052,011	716,104,941	561,663,600	30,889,025	-	57,235,287	-	1,365,892,853	(729,840,842)	214.7%	9,435,300
Жижиг бизнесийн зээл	1,396,878,234	1,663,946,851	157,768,068	892,606,625	16,823,746	17,761,056	2,371,292	2,751,277,638	(1,354,399,404)	197.0%	29,313,615
Хэрэглээний зээл	1,239,933,743	29,494,118	36,700	21,480,384	616,646,085	19,000	-	667,676,287	572,257,456	53.8%	16,312,925
Орон сууцны ипотекийн зээл	468,493,079	805,838,870	700	530,101	-	-	-	806,369,671	(337,876,592)	172.1%	3,704,556
Нийт	3,741,357,067	3,215,384,780	719,469,068	945,506,135	633,469,831	75,015,343	2,371,292	5,591,216,449	(1,849,859,382)		58,766,396

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)****Санхүүгийн хөрөнгийн чанар**

Банк зээл ба урьдчилгааны чанарыг дараах байдлаар зэрэглэлээр ангилдаг. Үүнд:

<u>Зээлийн зэрэглэл</u>	<u>Мүүди Рейтинг</u>	<u>Тодорхойлолт</u>
A	Aaa - A3	Маш сайн
B	Baa1 - B3	Сайн
C	Saa1 - Caa3	Хангалттай
D	Ca	Анхаарал татсан
E	C, D	Үнэ цэнийн бууралттай

Энэхүү зээлийн зэрэглэлийн үнэлгээний аргачлал нь зээлийн эргэн төлөлт хийгдсэн байдал, зээл барьцаа хөрөнгө, зээлийн зориулалт гэх мэт эрсдэлийн үзүүлэлтүүдийг үнэлж зээлийн зэрэглэлийг тогтоодог. Ингэснээр зээл болон урьдчилгааны чанарыг сегмент дотор нь бүлэглэх, харьцуулах боломжийг олгодог.

Үүнээс гадна Банк олон улсын зэрэглэл тогтоох байгууллагаас тогтоосон зээлжих зэрэглэлийн үнэлгээг бусад банк болон санхүүгийн байгууллагуудад байршуулсан хөрөнгө болон санхүүгийн хөрөнгө оруулалтын чанарыг үнэлэхэд ашигладаг. Банк нь хөрөнгийн биржид бүртгэлгүй санхүүгийн хөрөнгө оруулалтад үнэлгээ тогтоодоггүй.

Доорх хүснэгтэд нийт санхүүгийн хөрөнгүүдийг дээр дурдсан зээлийн зэрэглэлийн үнэлгээ болон олон улсын байгууллагаас тогтоосон зээлжих зэрэглэлийн үнэлгээнд үндэслэн үнэ цэнийн бууралтын санг оруулаагүй дүнгээр үзүүлэв.

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн хөрөнгийн чанар (үргэлжлэл)

	2025				2024			
	Түвшин 1 12 сараар	Түвшин 2 Дуусах хугацаагаар	Түвшин 3 Дуусах хугацаагаар	Нийт мян.төг	Түвшин 1 12 сараар	Түвшин 2 Дуусах хугацаагаар	Түвшин 3 Дуусах хугацаагаар	Нийт мян.төг
Зэрэглэл								
Хорогдуулсан өртгөөрх Монголбанк болон бусад банк, санхүүгийн байгууллагад байршуулсан харилцах, хадгаламж								
Маш сайн	1,111,724,988	-	-	1,111,724,988	876,584,690	-	-	876,584,690
Сайн	39,838,685	-	-	39,838,685	298,877,826	-	-	298,877,826
Нийт	1,151,563,673	-	-	1,151,563,673	1,175,462,516	-	-	1,175,462,516
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(544,082)	-	-	(544,082)	(572,337)	-	-	(572,337)
Дансны үнэ	1,151,019,591	-	-	1,151,019,591	1,174,890,179	-	-	1,174,890,179
Хорогдуулсан өртгөөрх харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа								
Маш сайн	1,717,843,333	-	-	1,717,843,333	1,575,109,255	-	-	1,575,109,255
Сайн	375,489,319	-	-	375,489,319	314,607,405	-	-	314,607,405
Хангалттай	1,645,929,276	-	-	1,645,929,276	1,264,073,976	-	-	1,264,073,976
Анхаарал татсан	212,962,479	31,792,064	-	244,754,543	243,932,456	58,812,404	-	302,744,860
Үнэ цэнийн бууралттай	-	-	103,869,013	103,869,013	-	-	74,965,903	74,965,903
Нийт	3,952,224,407	31,792,064	103,869,013	4,087,885,484	3,397,723,092	58,812,404	74,965,903	3,531,501,399
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(16,642,202)	(742,499)	(53,851,701)	(71,236,402)	(15,744,632)	(1,504,240)	(41,517,524)	(58,766,396)
Дансны үнэ	3,935,582,205	31,049,565	50,017,312	4,016,649,082	3,381,978,460	57,308,164	33,448,379	3,472,735,003
Хорогдуулсан өртгөөрх өрийн хэрэгслүүд								
Сайн	1,103,868,423	-	-	1,103,868,423	1,135,152,483	-	-	1,135,152,483
Нийт	1,103,868,423	-	-	1,103,868,423	1,135,152,483	-	-	1,135,152,483
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(651,058)	-	-	(651,058)	(1,260,203)	-	-	(1,260,203)
Дансны үнэ	1,103,217,365	-	-	1,103,217,365	1,133,892,280	-	-	1,133,892,280
Зээлийн үүрэг хариуцлага								
Маш сайн	66,749,903	-	-	66,749,903	59,129,130	-	-	59,129,130
Сайн	69,199,703	-	-	69,199,703	65,516,435	-	-	65,516,435
Хангалттай	53,562,885	-	-	53,562,885	22,315,821	-	-	22,315,821
Анхаарал татсан	19,355,403	934,555	-	20,289,958	27,852,289	213,177	-	28,065,466
Үнэ цэнийн бууралттай	-	-	15,246	15,246	-	-	53,147	53,147
Нийт	208,867,894	934,555	15,246	209,817,695	174,813,675	213,177	53,147	175,079,999
Үнэ цэнийн бууралтын хасагдуулга	(308,366)	(7,361)	(3,718)	(319,445)	(377,788)	(800)	(9,900)	(388,488)
Дансны үнэ	208,559,528	927,194	11,528	209,498,250	174,435,887	212,377	43,247	174,691,511

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.2 Зээлийн эрсдэл (Үргэлжлэл)**

Хугацаа хэтэрсэн зээлүүдийн насжилтын шинжилгээг дор үзүүлэв.

Хугацаа хэтэрсэн боловч үнэ цэнийн бууралтанд ороогүй санхүүгийн хөрөнгүүдийн насжилтын шинжилгээ

Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	2025	2025	2024	2024
	Нийт дансны үнэ мян.төг	Үнэ цэнийн бууралтын хасагдуулга мян.төг	Нийт дансны үнэ мян.төг	Үнэ цэнийн бууралтын хасагдуулга мян.төг
0-30	93,999,807	1,013,870	48,562,132	1,050,947
31-60	12,005,566	639,823	11,298,405	807,741
61-90	14,059,284	1,133,713	13,387,228	736,024
91-180	25,771,743	16,854,188	11,728,765	5,201,812
181-ээс дээш хоног	72,881,073	34,560,865	45,778,380	23,555,481
Нийт	218,717,473	54,202,459	130,754,910	31,352,005

31.3 Төлбөрийн чадварын эрсдэл

Банк хөрөнгийн өсөлтийг санхүүжүүлэх эх үүсвэрийн хомсдолд орох болон хүлээсэн үүргээ цаг хугацаанд нь биелүүлэх чадваргүй болох эрсдэлийг хөрвөх чадварын эрсдэл гэнэ. Банк хөрвөх чадварын эрсдэлийн хүлээн зөвшөөрөх эрсдэлийн хэм хэмжээг тодорхойлсон бөгөөд энэ нь харилцагчдын гэнэтийн их хэмжээний бэлэн мөнгөний татан авалтын үед хүлээсэн үүргээ биелүүлэх чадвар бүхий хөрвөх чадварын харьцаа үзүүлэлтийн доод хэмжээг тогтоосон байдаг. Түүнчлэн Банк нь нийт харилцагчдын төгрөгийн хадгаламжийн 13%, гадаад валютын хадгаламжийн 18%-тай тэнцэх бэлэн мөнгийг Монголбанканд заавал байршуулах ёстой.

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ

Доорх хүснэгтэд Банкны санхүүгийн өр төлбөрүүдийн дуусгавар болох хугацааг аливаа нэг хөнгөлөлтгүйгээр, гэрээний дагуу эргэн төлөх үүргүүдэд үндэслэн харууллаа. Урьдчилан мэдэгдсэний үндсэн дээр төлөгдөх ёстой өр төлбөрийн хувьд уг мэдэгдэл тэр даруй ирсэн гэж тооцсон боловч Банк харилцагчдын дийлэнх нь гэрээт хугацаанаасаа өмнө зарлагын гүйлгээ хийхгүй гэсэн хүлээлттэй байгаа ба хадгаламжийн татан авалтын түүхэн өгөгдлүүдэд үндэслэн Банкны хүлээж буй мөнгөн урсгалыг хүснэгтэд тусгаагүй болно.

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга
2025 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.3 Төлбөрийн чадварын эрсдэл (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөрийг гэрээний үлдэж буй хугацаагаар шинжилсэн шинжилгээ (Үргэлжлэл)

Санхүүгийн өр төлбөр	Хугацаагүй мян.төг	3 сараас доош мян.төг	3 - 6 сар мян.төг	6 сараас 1 жил хүртэл мян.төг	1 - 5 жил мян.төг	5-аас дээш жил мян.төг	Санхүүгийн өр төлбөрийн дискаунтлаагүй нийт дүн мян.төг	Дансны үнэ мян.төг
2025 оны 12 дугаар сарын 31								
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд								
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	-	66,855	509,206	772,018	5,464,094	-	6,812,173	6,812,173
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр								
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	-	3,074,022	-	-	-	-	3,074,022	3,074,022
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,364,456,563	314,419,293	384,993,866	662,722,528	596,999,623	1,151,339,373	4,474,931,246	3,749,383,957
Зээлээр авсан санхүүжилт	156,247,091	23,550,601	57,434,909	252,878,869	1,938,345,640	21,851,287	2,450,308,397	2,096,275,640
Түрээсийн өр төлбөр	-	1,073,442	3,558,255	1,990,724	6,446,353	-	13,068,774	11,380,292
Бусад өр төлбөр	-	33,552,788	36,377,215	67,827,714	58,181,368	5,755,886	201,694,971	57,930,337
Нийт	1,520,703,654	375,737,001	482,873,451	986,191,853	2,605,437,078	1,178,946,546	7,149,889,583	5,924,856,421
2024 оны 12 дугаар сарын 31								
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд								
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд	-	575,444	70,296	2,668,368	6,228,729	-	9,542,837	9,542,837
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр								
Бусад банк, санхүүгийн байгууллагын харилцах, хадгаламж	2,410,124	274,029,992	-	-	-	-	276,440,116	276,333,956
Харилцагчдын харилцах, хадгаламж	1,205,848,060	339,517,986	357,924,087	571,936,720	525,523,176	1,224,338,222	4,225,088,251	3,424,786,562
Зээлээр авсан санхүүжилт	10,733,187	98,064,783	223,596,359	576,352,764	1,018,570,993	3,122,567	1,930,440,653	1,727,756,398
Түрээсийн өр төлбөр	-	698,993	1,223,188	2,642,944	3,721,685	-	8,286,810	7,233,884
Бусад өр төлбөр	-	35,434,922	19,579,673	30,119,138	48,260,493	4,516,942	137,911,168	44,005,565
Нийт	1,218,991,371	748,322,120	602,393,603	1,183,719,934	1,602,305,076	1,231,977,731	6,587,709,835	5,489,659,202
Болзошгүй өр төлбөр болон үүрэг хариуцлага								
2025 оны 12 дугаар сарын 31								
Болзошгүй өр төлбөр (Тодруулга 28)	15,905,789	22,671,511	27,144,001	9,992,364	16,618,039	-	92,331,704	92,331,704
Санхүүгийн үүрэг хариуцлага (Тодруулга 28)	2,524,195	4,588,919	88,830,498	37,238,352	76,635,731	-	209,817,695	209,817,695
Нийт	18,429,984	27,260,430	115,974,499	47,230,716	93,253,770	-	302,149,399	302,149,399
2024 оны 12 дугаар сарын 31								
Болзошгүй өр төлбөр (Тодруулга 28)	29,952,551	19,028,880	19,932,462	21,122,761	4,353,248	15,611	94,405,513	94,405,513
Санхүүгийн үүрэг хариуцлага (Тодруулга 28)	508,617	4,633,481	17,129,714	14,702,887	138,104,837	463	175,079,999	175,079,999
Нийт	30,461,168	23,662,361	37,062,176	35,825,648	142,458,085	16,074	269,485,512	269,485,512

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)**31.4 Зах зээлийн эрсдэл**

Зах зээлийн эрсдэл гэдэг нь санхүүгийн зах зээл дээрх сөрөг өөрчлөлт болон үнийн хэлбэлзлээс эдийн засгийн үнэ цэн, орлогын хэмжээнд учирч болох алдагдлыг хэлнэ. Банкны зах зээлийн эрсдэлийг удирдах ерөнхий журам нь Банкны санхүүгийн эрсдэлүүд болох зах зээл, өөрийн хөрөнгө, хөрвөх чадварын эрсдэлийг зохистой хэмжээнд удирдах, улмаар өөрийн хөрөнгө болон хөрвөх чадвартай активын нөөцийг үр ашигтай боломжит түвшинд байлгахад чиглэсэн байдаг.

Хүүгийн түвшний эрсдэл

Хүүгийн эрсдэл гэдэг нь хүүгийн түвшний өөрчлөлт болон түүний тогтворгүй байдлаас банканд үүсэх сөрөг нөлөө болон алдагдлыг хэлнэ. Банкны зээлийн болон санхүүжилтийн, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаанууд нь хүүгийн эрсдэлийг бий болгодог. Хүүгийн хувь хэмжээний өөрчлөлт нь Банкны хүүгийн цэвэр орлогод тэр даруй нөлөөлдөг бол урт хугацаанд Банкны өөрийн хөрөнгөд нөлөөлдөг. Банкны эрсдэлийн удирдлага хариуцсан нэгж нь хүүгийн позитивд хүлээн зөвшөөрөгдсөн эрсдэлийн хэм хэмжээний хэрэгжилтэд тогтмол хяналт тавин ажилладаг.

Дараах хүснэгтэд Банкны орлогын тайлангийн зүйлүүдийн, бусад бүх хувьсагчууд тогтмол байх үед хүүгийн хувь хэмжээний зохистой, боломжит өөрчлөлтүүдэд үзүүлэх мэдрэмжийг харуулав. Орлогын тайлангийн мэдрэмж гэж нэг жилийн хүүгийн цэвэр орлогод хүүгийн өөрчлөлт (2024 болон 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн хөвөгч хүүгийн өөрчлөлт)-ийн үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Валют	2025 Өсөлт/ (Бууралт)	2025 Цэвэр хүүгийн орлогын мэдрэмж мян.төг	2024 (Өсөлт/ (Бууралт)	2024 Цэвэр хүүгийн орлогын мэдрэмж мян.төг
Америк доллар	+120	401,978	+120	(1,006,646)
Төгрөг	+120	(9,821,376)	+120	(4,989,288)
Америк доллар	-120	(401,978)	-120	1,006,646
Төгрөг	-120	9,821,376	-120	4,989,288

Гадаад валютын эрсдэл

Гадаад валютын ханшийн эрсдэл гэдэг нь гадаад валютын ханшийн өөрчлөлт болон ханшийн тогтворгүй байдлаас Банканд үүсэх сөрөг нөлөө болон алдагдлыг хэлнэ. Банк нь гадаад валютын позицуудын эрсдэлийн хязгааруудыг тогтоож, тэдгээрийн гүйцэтгэл хүлээн зөвшөөрөх хэм хэмжээндээ байгаа эсэхэд тогтмол хяналт тавин ажилладаг. Үүнээс гадна Банк гадаад валютын эрсдэлийг удирдах болон үнэлэхдээ "Хамгийн их эрсдэлийг тооцох аргачлал" (ХИЭТА)-ыг ашигладаг.

Хамгийн их эрсдэлийг тооцох аргачлал

ХИЭТА нь Банкны зах зээлийн эрсдэлийн удирдлагын салшгүй нэг хэсэг бөгөөд 2007 оны 3 дугаар сараас эхлэн үйл ажиллагаандаа хэрэглэж байна. Энэхүү аргачлалыг зах зээлийн хэвийн орчинд зах зээлийн эрсдэлийг хэмжихэд ашигладаг. Өөрөөр хэлбэл зах зээлийн хэвийн орчинд нөлөө үзүүлж буй эрсдэлийн хүчин зүйлүүдэд гарч буй аливаа өөрчлөлтүүд нь хэвийн тархалттай байна гэж авч үздэг. Банк гадаад валютын позицоос үүсэх нэг өдрийн болзошгүй алдагдлын хэмжээ болох ХИЭТА-ыг 99 хувийн итгэлцлийн түвшинд вариаци/ковариацийн аргачлалыг ашиглаж тооцдог. Гадаад валютын позицид үүсч болох ХИЭТА алдагдлын хэмжээг 99 хувийн итгэлцлийн түвшинд тооцоолж гаргасныг дор үзүүлэв. Үүнд:

Вариаци / Ковариаци

	2025 мян.төг	2024 мян.төг
12-р сарын 31-ний өдөр	82,192	55,427
Өдрийн дундаж	70,555	75,481
Оны дээд хэмжээ	190,939	297,003
Оны доод хэмжээ	22,043	18,345

ХАСБАНК ХК

Санхүүгийн тайлангийн тодруулга 2023 оны 12 дугаар сарын 31

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

Санхүүгийн хөрөнгө ба өр төлбөр	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Евро мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2025 оны 12 дугаар сарын 31					
Санхүүгийн хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	79,881,959	107,198,555	2,783,819	48,375,604	238,239,937
Монголбанк дахь заавал байлгах нөөц	391,164,502	76,418,930	1,409,896	35,514,836	504,508,164
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд					
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд*	4,770,541	1,927,779,661	1,256,016	13,206,954	1,947,013,172
Санхүүгийн хэрэгслүүд	147,862,972	-	-	-	147,862,972
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	165,355,679	-	-	-	165,355,679
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө					
Өмчийн хэрэгслүүд	3,728,279	-	-	-	3,728,279
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө					
Бусад банк, санхүүгийн байгууллагад					
байршуулсан харилцах, хадгаламж	-	413,670,022	832,593	28,811,271	443,313,886
Өрийн хэрэгслүүд	1,067,748,033	35,469,332	-	-	1,103,217,365
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,977,136,924	39,512,158	-	-	4,016,649,082
Бусад санхүүгийн хөрөнгө	7,705,377	3,683,133	1,273,328	81,968	12,743,806
Нийт санхүүгийн хөрөнгө	5,845,354,266	2,603,731,791	7,555,652	125,990,633	8,582,632,342
Санхүүгийн өр төлбөр					
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд					
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд*	1,806,117,695	19,121,584	-	82,420,005	1,907,659,284
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр					
Бусад банкны харилцах, хадгаламж	466,986	1,971,908	224,190	410,938	3,074,022
Харилцагчдын харилцах, хадгаламж	3,070,163,413	621,090,261	6,554,436	51,575,847	3,749,383,957
Зээлээр авсан эх үүсвэр	172,491,751	1,923,783,889	-	-	2,096,275,640
Түрээсийн өр төлбөр	11,380,292	-	-	-	11,380,292
Бусад санхүүгийн өр төлбөр	53,534,757	1,483,920	1,952,162	959,498	57,930,337
Нийт санхүүгийн өр төлбөр	5,114,154,894	2,567,451,562	8,730,788	135,366,288	7,825,703,532
Цэвэр санхүүгийн хөрөнгө(өр төлбөр)	731,199,372	36,280,229	(1,175,136)	(9,375,655)	756,928,810

* Үүссэн валют тус бүрийн нийт дүнгээр илэрхийлсэн

31. Эрсдэлийн удирдлага (Үргэлжлэл)

31.4 Зах зээлийн эрсдэл (Үргэлжлэл)

Гадаад валютын эрсдэл (Үргэлжлэл)

Дараах хүснэгтэд гадаад валютын эрсдэлд өртөж болох Банкны хөрөнгийн дүнг 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаар үзүүлэв. Хүснэгтэд санхүүгийн хөрөнгө, өр төлбөрүүдийн бүртгэлийн дүнг гадаад валют тус бүрээр бүлэглэн үзүүлэв.

Санхүүгийн хөрөнгө, өр төлбөр	Төгрөг мян.төг	Ам.доллар мян.төг	Евро мян.төг	Бусад мян.төг	Нийт мян.төг
2024 оны 12 дугаар сарын 31					
Санхүүгийн хөрөнгө					
Бэлэн мөнгө ба Монголбанк дахь харилцах	21,394,225	8,166,497	213,448	4,139,891	33,914,061
Монголбанк дахь заавал байлгах нөөц	301,049,522	36,540,617	1,093,805	59,206,929	397,890,873
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд					
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд*	22,605,239	1,558,273,956	-	-	1,580,879,195
Санхүүгийн хэрэгслүүд	112,300,780	-	-	-	112,300,780
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	209,855,668	-	-	-	209,855,668
БҮЦБДО-д бүртгэх санхүүгийн хөрөнгө					
Өмчийн хэрэгслүүд	3,910,731	-	-	-	3,910,731
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн хөрөнгө					
Бусад банк, санхүүгийн байгууллагад					
байршуулсан харилцах, хадгаламж	137,039,511	604,685,030	3,592,862	30,779,365	776,096,768
Өрийн хэрэгслүүд	1,133,892,280	-	-	-	1,133,892,280
Харилцагчдад олгосон зээл ба урьдчилгаа	3,430,651,462	42,083,541	-	-	3,472,735,003
Бусад санхүүгийн хөрөнгө	16,662,684	2,910,662	4,941	51,855	19,630,142
Нийт санхүүгийн хөрөнгө	5,389,362,102	2,252,660,303	4,905,056	94,178,040	7,741,105,501
Санхүүгийн өр төлбөр					
БҮЦАА-д бүртгэх санхүүгийн хэрэгслүүд					
Санхүүгийн үүсмэл хэрэгслүүд*	1,511,288,526	13,681,000	-	55,401,783	1,580,371,309
Хорогдуулсан өртгөөрх санхүүгийн өр төлбөр					
Бусад банкны харилцах, хадгаламж	137,332,207	138,280,867	73,967	646,915	276,333,956
Харилцагчдын харилцах, хадгаламж	2,854,837,444	523,081,833	5,825,918	41,041,367	3,424,786,562
Зээлээр авсан эх үүсвэр	186,241,540	1,541,514,858	-	-	1,727,756,398
Түрээсийн өр төлбөр	7,233,884	-	-	-	7,233,884
Бусад санхүүгийн өр төлбөр	36,513,330	5,683,104	498,924	1,310,207	44,005,565
Нийт санхүүгийн өр төлбөр	4,733,446,931	2,222,241,662	6,398,809	98,400,272	7,060,487,674
Цэвэр санхүүгийн хөрөнгө(өр төлбөр)	655,915,171	30,418,641	(1,493,753)	(4,222,232)	680,617,827

* Үүссэн валют тус бүрийн нийт дүнгээр илэрхийлсэн

Урьдчилан төлөлтийн эрсдэл

Урьдчилан төлөлтийн нөлөө гэдэг нь Банкны үйлчлүүлэгч болон харилцагч нь хүлээж байснаас өмнө төлбөрөө төлсөн болон төлөхийг хүссэнээс Банкны санхүүгийн үзүүлэлтэд үзүүлэх нөлөөллийг хэлнэ.

Банк хүүгийн цэвэр орлогод үзүүлэх энэхүү урьдчилан төлөлтийн нөлөөллийг тооцохдоо хялбаршуулсан аргачлалыг хэрэглэдэг.

Үүнд хэрэв бусад бүх хувьсагчдыг тогтмол гэж үзэн эргэн төлөгдөх санхүүгийн хэрэгслүүдийн 20% нь жилийн эхэнд урьдчилан төлөгдсөн тохиолдолд жилийн эцсийн татварын өмнөх ашиг 45,337 сая (2024 онд: 56,171 сая) төгрөгөөр буурахаар байсан байна.

31.5 Үйл ажиллагааны эрсдэл

Үйл ажиллагааны эрсдэл гэдэг нь дотоод процесс, хүний нөөц болон системийн үйл ажиллагаа хангалтгүй буюу доголдолтой, эсхүл гадны хүчин зүйлсийн улмаас (үүнд эрх зүйн эрсдэлийг оролцуулан) Банк хүлээж болзошгүй алдагдлыг хэлнэ. Банкны үйл ажиллагааны эрсдэл хариуцсан нэгж нь процесс хариуцсан нэгжүүдийн үйл ажиллагааны эрсдэлээс урьдчилан сэргийлэх, эрсдэлийг илрүүлэх, бууруулах чиглэлд хэрэгжүүлж буй хяналтууд нь үр дүнтэй байгаад хяналт тавих, тэдгээрийг заавар, зөвлөмжөөр ханган ажиллах чиг үүрэгтэй байдаг. Түүнчлэн Банк процесст хийгдэх эрсдэлийн үнэлгээ болон түүнд хэрэгжиж буй хяналтын мониторингоор дамжуулан үйл ажиллагааны эрсдэлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилладаг.

32. Хөрөнгийн зохистой харьцаа

Банк бизнесийн салшгүй эрсдэлийг өөрийн хөрөнгөдөө тулгуурлан үр ашигтай удирддаг. Монголбанкнаас тогтоосон дүрэм, харьцаануудыг ашиглах замаар Банкны өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хянадаг. 2024 оны турш Банк нь өөрийн хөрөнгөд хөндлөнгөөс тавьдаг бүх шалгууруудыг бүрэн хангаж ажилласан.

Капиталын удирдлага

Банкны капиталын удирдлагын үндсэн зорилго нь хөндлөнгөөс тавигдсан зохистой харьцааны шалгууруудыг биелүүлэх ба бизнесээ дэмжиж хувь нийлүүлэгчдийн үнэлэмжийг ихэсгэхийн тулд зээлийн эрсдэлийн түвшин болон өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хадгалахад оршдог.

Банк өөрийн хөрөнгийн бүтцийг удирдаж, эдийн засгийн нөхцөл байдал болон үйл ажиллагааны эрсдэлийн шинж чанарт орсон өөрчлөлтүүдийг харгалзан капиталын бүтцэдээ залруулга хийдэг байна. Банк капиталынхаа бүтцээ хадгалах эсхүл тохируулахын тулд хувь нийлүүлэгчдэд төлөх ногдол ашгийн хэмжээг тохируулах, хувь нийлүүлэгчид хөрөнгийг нь эргүүлэн төлөх, шинээр өөрийн хөрөнгийн хэрэгсэл гаргах, эсхүл өөрийн хөрөнгөд уялдсан үнэт цаас гаргах зэрэг арга замуудыг ашигладаг байна.

Зохицуулалттай капитал

Монголбанкнаас арилжааны банкуудын өөрийн хөрөнгийн зохистой харьцааг хамгийн багадаа 9% (2024 онд: 9%), өөрийн хөрөнгө эрсдэлээр жигнэсэн активын харьцааг 12% (2024 онд: 12%)-иас доошгүй байхаар тогтоосон байдаг бөгөөд эдгээр харьцаа нь эрсдэлийн уг шинж чанараар нь тохируулсан актив болон нийт капиталыг авч тооцоологдсон байдаг. Банкны 12 дугаар сарын 31-ний өдрийн байдлаарх өөрийн хөрөнгийн зохистой харьцааг дараах байдлаар үзүүлэв:

	2025 мян.төг	2024 мян.төг
Өөрийн хөрөнгийн харьцаа	20.1%	19.3%
Эрсдэлээр жигнэсэн өөрийн хөрөнгийн харьцаа	20.1%	19.3%
I зэрэглэлийн хөрөнгө		
Энгийн хувьцаа	105,270,000	105,270,000
Халаасны хувьцаа	(267,282)	(29,668)
Нэмж төлөгдсөн капитал	28,513,791	30,388,871
Бусад сан	11,439,408	11,439,408
Хуримтлагдсан ашиг	642,607,008	515,406,909
Монголбанкны журмын дагуу тохируулга	(38,985)	(81,392)
Нийт I зэрэглэлийн хөрөнгийн дүн	<u>787,523,940</u>	<u>662,394,128</u>
II зэрэглэлийн хөрөнгө		
Бусад	-	-
Нийт II зэрэглэлийн хөрөнгийн дүн	<u>-</u>	<u>-</u>
Нийт капитал/капиталын суурь	<u>787,523,940</u>	<u>662,394,128</u>
	2025 мян.төг	2024 мян.төг
Эрсдэлээр жигнэсэн хөрөнгүүд	<u>3,921,216,266</u>	<u>3,439,528,364</u>

33. Тайлагналын дараах үйл явдал

Банк нь 2026 оны 2 дугаар сарын 16-ны өдөр жилийн эцсийн ашгаасаа нэгж хувьцаа бүрд 30 төгрөгийн ногдол ашиг олгохоор шийдвэрлэсэн. Монголбанк нь ногдол ашиг зарлах шийдвэрийг зөвшөөрөх ёстой бөгөөд санхүүгийн тайлан гаргах өдрийн байдлаар Монголбанкны зөвшөөрөл хараахан олгогдоогүй байна.

Тайлагналын өдрөөс хойш Банкны үйл ажиллагаанд нөлөөлсөн болон нөлөөлж болох өөр ямар нэг үйл явдал, нөхцөл байдал үүсээгүй болно.

34. Монгол хэл дээрх орчуулга

Эдгээр санхүүгийн тайлангуудыг мөн Англи хэл дээр бэлтгэсэн болно. Монгол, Англи хувилбаруудын хооронд утга, агуулгын зөрүү гарах тохиолдолд Англи хувилбарыг баримтална.

2025 оны Арван хоёрдугаар сар 31

(Төгрөгөөр)

№	Дансны нэр	Эхний үлдэгдэл /2024.12.31/	Эцсийн үлдэгдэл /2025.12.31/
1	Зээл, зээлтэй адилтгах хөрөнгөнд хамаарах үүрэг	269,485,511.871.47	302,153,341,304.55
2	Барьцаа хөрөнгө	6,160,955,705,646.60	7,428,193,767,606.55
3	Тэнцлээс хассан хөрөнгө	98,056,738,056.83	82,476,729,281.68
4	Дериватив санхүүгийн хэрэгсэл	1,643,418,137,216.35	2,071,972,007,901.70
5	Харилцагчийн өмнөөс батлан даасан хөрөнгө	-	-
6	Барьцаанд тавьсан хөрөнгө	-	-
7	Тэнцлийн гадуурх бусад дансууд	354,823,567,149.34	518,232,604,991.30
Нийт		8,526,739,659,940.59	10,403,028,451,085.80

ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

САНХҮҮ ХАРИУЦСАН ЗАХИРАЛ



Г.ЦЭВЭГЖАВ

Г.ТАМИР